



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 26 (503)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Хоршооны тухай хуулийн зарим заалтыг дагаж мөрдөх журмын тухай*

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

- *Хоршооны тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2007 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2007 оны долдугаар сарын 14

№26 (503)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | | |
|------|--|-----|
| 314. | Хоршооны тухай хуулийн зарим заалтыг дагаж мөрдөх журмын тухай | 589 |
| 315. | Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 590 |
| 316. | Үндэсний их баяр наадмын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай | 591 |

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|--|------------|-----|
| 317. | Бүтээгдэхүүн хуваах гэрээ батлах тухай | Дугаар 148 | 591 |
|------|--|------------|-----|

Гурав. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

- | | | | |
|------|---|-----------|-----|
| 318. | Хоршооны тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай | Дугаар 26 | 592 |
| 319. | Компанийн тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай | Дугаар 27 | 596 |

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

- | | | |
|------|---|-----|
| 320. | 1978 оны протоколоор өөрчлөлт оруулсан Далайг хөлөг онгоцноос бохирдуулахаас сэргийлэх тухай 1973 оны олон улсын конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1997 оны протокол | 599 |
|------|---|-----|

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 06 дугаар сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

ХОРШООНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хоршооны тухай хууль¹-ийн 3 дугаар зүйлийн 3.4.3-т заасан хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэхээр улсын бүртгэлд бүртгүүлсэн хоршоо мөн хуулийн 48¹ дүгээр зүйлийн 48¹.3-т заасны дагуу хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах тухай хүсэлтээ Санхүүгийн зохицуулах хороонд 2007 оны 10 дугаар сарын 1-ний дотор гаргана.

2 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороонд хүсэлтээ ирүүлээгүй хоршоо хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

3 дугаар зүйл. Хадгаламж, зээлийн үйл ажиллагааг дагнан эрхлэхээр улсын бүртгэлд бүртгүүлсэн хоршоо энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороонд хүсэлтээ гаргаагүй бол тухайн хоршоог татан буулгах асуудлыг Санхүүгийн зохицуулах хорооны нэхэмжлэлээр шүүх шийдвэрлэнэ.

4 дүгээр зүйл. Хоршооны тухай хуулийн 3.4.1, 3.4.2, 3.4.4-3.4.8-д заасан үйл ажиллагаа болон хадгаламж, зээлийн үйл ажиллагааг нэгэн зэрэг эрхлэхээр улсын бүртгэлд бүртгүүлсэн хоршоо энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан

¹ Хоршооны тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1998 оны 2, Хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 48, 2005 оны 46 дугаарт тус тус хэвлэгдсэн.

хугацаанд Санхүүгийн зохицуулах хороонд хүсэлт гаргаагүй бол хадгаламж, эзэлийн үйл ажиллагаа дуусгавар болсонтой холбогдуулан өөрийн дүрэмд зохих өөрчлөлт оруулж, уг дүрмийг энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан хугацаа дуусгавар болсноос хойш 1 сарын дотор Улсын бүртгэлийн албанд бүртгүүлнэ.

5 дугаар зүйл. Энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан хугацаанд дүрэмд оруулсан өөрчлөлтийг бүртгүүлэхээр өргөдөл гаргаагүй хоршоог татан

буулгах асуудлыг Улсын бүртгэлийн албаны нэхэмжлэлээр шүүх шийдвэрлэнэ.

6 дугаар зүйл. Энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө Хоршооны тухай хуулийн 48, 4 дэх хэсгийн дагуу хадгаламж, эзэлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан хоршоонд энэ хууль хамаарахгүй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 07 дугаар
сарын 06-ны өдөр

Улаанбаатар
хот

ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 8.7, 8.8, 8.9 дэх хэсэг нэмсүгэй:

"8.7. Уяачид улс, аймаг, сумын цолыг жил бүрийн цагаан сарын баяраар олгоно.

8.8. Энэ хуулийн 8.3 - 8.6-д заасны дагуу уяачийн амжилтыг тооцож цол олгохдоо тухайн уралдааныг зохион байгуулж буй Хурдан морины салбар хороо /комисс/ -нд уяачаар бүртгүүлсэн иргэний амжилтад тооцон уг цолыг олгох бөгөөд түүрүүлсэн, айрагдсан нэг морины нэг удаагийн амжилт нь зөвхөн энэ зүйлд заасан нэг уяачид цол олгох үндэслэл болно.

8.9. Улсын баяр наадмын хурдан морины уралдаанд 6-10 дугаар байр эзэлсэн бүх насны хурдан морины баяр наадмын хурдан морины салбар хороо орон даяар нийтэд зарлана."

2 дугаар зүйл. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 7 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"7 дугаар зүйл. Үндэсний бөхийн барилдаан

7.1 Улсын баяр наадамд 512 бөх барилдах бөгөөд дараахь амжилт гаргасан бөхөд дор дурдсан цол олгоно:

/Энэ хэсэгт Монгол Улсын Ерөнхийлөгч 2007 оны долдугаар сарын 10-ны өдөр хориг тавьсан./

- 7.1.1. тав давсан бөхөд улсын начин;
- 7.1.2. зургаа давсан бөхөд улсын харцага;
- 7.1.3. долоо давсан бөхөд улсын заан;
- 7.1.4. найм давсан бөхөд улсын гарьд;

7.1.5. ес даван түүрүүлсэн бөхөд улсын арслан;

7.1.6. улсын арслан цолтон түүрүүлсэн бол улсын аварга;

7.1.7. улсын аварга түүрүүлсэн бол улсын далай аварга;

7.1.8. улсын далай аварга түүрүүлсэн бол улсын даян аварга;

7.1.9. улсын даян аварга түүрүүлсэн бол улсын дархан аварга.

7.2. Улсын баяр наадамд 1024 бөх барилдсан бөгөөд улсын арслангаас бага цолтой бөх 9 давсан бол үзүүр түрүүний барилдааны өмнө түүнд улсын арслан цол олгож, улмаар 10 давж түүрүүлбэл улсын аварга цол олгоно.

/Энэ хэсэгт Монгол Улсын Ерөнхийлөгч 2007 оны долдугаар сарын 10-ны өдөр хориг тавьсан./

7.3. Аймгийн баяр наадамд 128 бөх барилдах бөгөөд тав давсан бөхөд аймгийн начин, үзүүрлэсэн бөхөд аймгийн заан, түүрүүлсэн бөхөд аймгийн арслан цол олгоно.

7.4. Энэ хуулийн 7.3-т заасан наадамд 256 бөх барилдсан бол тав давсан бөхөд аймгийн начин, зургаа давсан бөхөд аймгийн харцага, долоо давсан бөхөд аймгийн заан, найм давсан бөхөд аймгийн арслан цол олгоно.

7.5. Сумын баяр наадамд 64 бөх барилдах бөгөөд үзүүрлэсэн бөхөд сумын начин, түүрүүлсэн бөхөд сумын заан цол олгоно.

7.6. Энэ хуулийн 7.5-д заасан наадамд 128 бөх барилдсан тохиолдолд тав давсан бөхөд сумын начин, зургаа давсан бөхөд сумын харцага, долоо давсан бөхөд сумын заан цол олгоно.

7.7.Зэвсэгт хүчин, бусад цэргийн хэмжээнд нэгдсэн журмаар зохион байгуулагдаж буй цэргийн наадмаар уламжлалыг харгалзан аймгийн баяр наадмынхтай ижил нөхцөлөөр цэргийн начин, цэргийн харцага, цэргийн заан, цэргийн арслан цолыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр олгож болно.

7.8.Үндэсний бөхийн барилдааны нэг, хоёр, дөрвийн даваанд бөхчүүдийг цолны болон амжилтынх нь эрэмбээр тулгаж барилдуулах бөгөөд бусад даваанд дээрх эрэмбээр ам авч барилдана.

7.9.Энэ хуулийн 7.8-д заасан амжилтын эрэмбээр ам авах заалт нь дархан аварга цолтонд хамаарахгүй.

7.10.Энэ хуулийн 7.2, 7.4, 7.6-д заасан барилдааныг тэгш ойн Үндэсний их баяр наадмын үеэр зохион байгуулж болно."

3 дугаар зүйл. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8.5-ын "10" гэснийг "6" гэж, "20" гэснийг "12" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 10.2, 10.9, 12.4.5, 14.3 дахь хэсгийг тус тус хассугай.

Энэ хэсэгт Монгол Улсын Ерөнхийлөгч 2007 оны долдугаар сарын 10-ны өдөр хориг тавьсан./

5 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 07 дугаар сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

**ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ
ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Үндэсний их баяр наадмын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн "улсын гарьд" гэсний дараа "улсын наадамд түрүүлсэн улсын арслан цолтон 10 даван түрүүлсэн бол улсын далай аварга" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2003 оны 6 дугаар сарын 19-ний өдөр батлагдсан Үндэсний их баяр наадмын тухай хуулийг дагаж мөрдөхөөс өмнө

болон уг хууль батлагдсаны дараа улсын баяр наадамд 10 даван түрүүлсэн бөхөд хамааруулж хэрэглэнэ.

3 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 06 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 148

Улаанбаатар хот

**Бүтээгдэхүүн хуваах гэрээ
батлах тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Газрын тосны хайгуулын Нялга-ХVI талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах талаар Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар, Канад Улсын "Шаман Ресурсес"

компанийн хооронд 2007 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээг баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД М.ЭНХБОЛД
ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ
САЙД Ц.ДАВААДОРЖ**

2007 оны 06 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 26

Улаанбаатар
хот

ХОРШООНЫ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Хоршооны тухай Монгол улсын хуулийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

Хоршооны тухай хуулийн /цаашид Хуулийн гэр/ Монгол улсын хуулийн зарим зүйл, заалтыг дор дурдснаар тайлбарласгай.

1. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан **"эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилго"** гэдэгт хоршоо хамтарсан үйл ажиллагааныхаа үр дүнгээр бүх гишүүдийнхээ ашиг сонирхол, шаардлагыг хангах явдлыг ойлгоно.

2. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т заасан **"дундын хоршооны гишүүдийн 51-ээс доошгүй хувь нь хоршоо байна"** гэж хоёр болон түүнээс дээш хоршоо нь аж ахуйн үйл ажиллагаагаа хамтран эрхлэх зорилгоор бусад хэлбэрийн хуулийн этгээдтэй хамтран дундын хоршоо байгуулахаар бол тухайн дундын хоршооны гишүүдийн 51-ээс доошгүй хувь нь хоршоо байхыг хэлнэ.

3. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-8-д заасан **"дүрэмд заасан үйл ажиллагаа"** гэдэгт энэ зүйлийн 3.4.1-3.4.7-д туссан үйл ажиллагааны төрлүүдээс гадна хуулиар хориглоогүй бусад төрлийн үйл ажиллагаа хамаарах бөгөөд тэдгээрийн аль алиныг нь хоршооны дүрэмд заавал заасан байна гэж ойлгоно.

4. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.5-д **"хэд хэдэн үйл ажиллагааг нэгэн зэрэг эрхэлж болно"** гэж заасны дагуу хоршоо энэ Хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-т заасан үйл ажиллагааны хоёроос дээш хэдэн ч төрлийн үйл ажиллагааг нэгэн зэрэг явуулах тохиолдолд үйл ажиллагаа тус бүрийг дүрэмд тусгаж, улсын бүртгэлд бүртгүүлэн, хуульд заасан тохиолдолд холбогдох зөвшөөрлийг авсан байвал зохино.

5. Хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан хоршооны **"оорийн эд хөрөнгө"** гэдэгт Хуулийн 8 дугаар зүйлд заасан эх үүсвэрээс бүрдэж, тухайн хоршооны санхүүгийн данс бүртгэлд тусгагдсан үндсэн ба эргэлтийн эд хөрөнгийг хамааруулна.

Хоршооны эд хөрөнгийн хэмжээг тодорхойлохдоо татварын байгууллагад хамгийн сүүлд гаргасан тайлан тэнцэл, түүнийг баталгаажуулсан дүгнэлтийг үндэслэнэ. Үндсэн болон эргэлтийн эд хөрөнгөөс бусдад төлөх өр төлбөрийг хасаж, үлдэх үнийн дүнгээр хоршооны өөрийн эд хөрөнгийн хэмжээг тогтооно.

6. Хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т заасан **"хоршооны эд хөрөнгө хүрэлцэхгүй тохиолдолд түүний үүргийг гишүүд нь нөхөж хариуцна"** гэдэг нь дүрэмд заасан үйл ажиллагааны улмаас бий болсон үүргийг хариуцахад хоршооны өөрийн эд хөрөнгө хүрэлцэхгүй болсон тохиолдолд түүний үүрэг, өр төлбөрийг хоршооны гишүүд нөхөж төлөхдөө гэр бүлийн гишүүний хуваарьт хөрөнгө болон бусадтай хамтран өмчлөх дундын эд хөрөнгөөс өөрт ногдох хэсгээр, хоршооны дүрэмд заасан бол тогтоосон хэмжээгээр, заагаагүй бол өөрт ногдох хэсгээр бүрэн хариуцлага хүлээхийг хэлнэ.

7. Хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т заасан **"гишүүдийн хүлээх нөхөх хариуцлагын хэмжээг хязгаарлах эсэхийг дүрмээр зохицуулна"** гэдэг нь хоршооны гишүүдийн нөхөх хариуцлагыг хязгаарлах эсэх, хязгаарлавал ямар үндэслэлээр хязгаарлахыг дүрэмд заавал тусгасан байхыг хэлнэ. Гишүүдийн хүлээх хариуцлагын хэмжээг хоршооны эд хөрөнгөөс гишүүнд оногдох хэмжээтэй харьцуулах, хоршоонд хөдөлмөрийн оролцоо, оюуны өмч нийлүүлсэн байдлыг харгалзах зэргээр гишүүдийн нөхөх хариуцлага хязгаартай байх эсэх асуудал хоршооны дүрэмд зааснаар зохицуулагдана.

8. Хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т **"хадгаламж, зээлийн хоршоо үйл ажиллагааныхаа улмаас бий болсон үүргийг өөрийн хөрөнгөөр хүлээнэ"** гэж зааснаар тухайн хоршооны хадгаламж болон зээлийн харилцаанаас бий болсон үүргийг хоршоо өөрийн хөрөнгө болох гишүүдийн оруулсан хувь хөрөнгө, нөөц сан, хуваарилгаагүй орлого, хандив, нийгмийн хөгжлийн сан, тухайн жилийн цэвэр ашгаар хариуцна.

Харин хоршооны мөнгөн хадгаламжид авсан мөнгөн хөрөнгө тухайн хоршооны эд хөрөнгөд хамаарахгүй.

9. Хуулийн 8 дугаар зүйлийн 5.1.4-т заасан **"бэлэглэсэн хөрөнгө"** гэж тухайн хоршооны өмчлөлд түүний гишүүн болон бусад этгээдээс

Иргэний хуулийн 276, 277 дугаар зүйлд заасны дагуу тодорхой хөрөнгийг хариу төлбөргүй шилжүүлснийг ойлгоно.

Мөн зүйл, заалтын "хандивласан хоронго" гэж тухайн хоршоонд Иргэний хуулийн 276 дугаар зүйлийн 276.5, 276.6-д заасны дагуу тодорхой хөрөнгийг тусгай зориулалтаар хандивын журмаар бэлэглэсэн байхыг хэлнэ.

10. Хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 23 дугаар зүйлийн 23.8, 23.11-т заасан "гишүүдийн дийлэнх олонхийн саналаар" гэдгийг хоршооны хуралд оролцож байгаа гишүүдийн гуравны хоёр буюу 66.6 хувийн саналаар гэж ойлгох бөгөөд харин Хуулийн 23 дугаар зүйлийн 23.5-д заасан "дийлэнх олонх" гэдгийг хоршооны бүх гишүүдийн гуравны хоёр гэж ойлгож хэрэглэнэ.

11. Хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4-т заасан "нэг хувийг буцаан олгоно" гэсний дагуу хоршоог улсын бүртгэлд бүртгэсэн тухай тэмдэглэлийг бүртгэлийн байгууллага хоршооны дүрэмд тусгаж, тэмдэглэл бүхий уг дүрмийн баталгаажуулсан хувийг хоршоонд өгнө.

12. Хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5-д заасан "өргөдөл гаргагчид албан ёсоор мэдэгдэж, баримт бичгийг нь буцаана" гэдэг нь хоршоог бүртгүүлэх өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг Хоршооны тухай хуульд заасан шаардлагыг хангаагүй гэж бүртгэлийн байгууллага үзвэл улсын бүртгэлд бүртгэхэд саад болж буй холбогдох үндэслэлийг зааж, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.-д зааснаар хоршоог бүртгэхээс татгалзсан тухай шийдвэр гаргах ба энэ тухай шийдвэрийг баримт бичгийн хамт өргөдөл гаргагчид буцаан хүргүүлэхийг хэлнэ.

13. Хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасан "нийтэд мэдээлнэ" гэдэг нь бүртгэх байгууллагаас хоршоог улсын бүртгэлд бүртгэсэн тухай төв, орон нутгийн өдөр тутмын сонин, радио, телевиз болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгсэл, түүнчлэн нийтэд хүртээлтэй бусад аргаар мэдээлсэн байхыг ойлгоно.

14. Хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасан хоршооны "үйлчилгээг ашиглаж, холбогдох хариуцлагыг хүлээх чадвартай иргэн" гэдгийг хоршооноос явуулж байгаа үйл ажиллагаанд биечлэн оролцож, түүний үйлчилгээг өөрийн ахуй амьдралдаа ашиглах талаар хоршооны дүрмээр тогтоосон эрх, үүргийг зөвшөөрч, уг хоршооны үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээнээс үүссэн үүргийг хоршоонд нийлүүлсэн эд хөрөнгөөрөө болон гэр бүлийн эд хөрөнгийн өөрт оногдох хэсгээр нөхөн төлөх чадвартай, Иргэний хуулийн 16 дугаар зүйлийн 16.4 -т зааснаар арван зургаан нас хүрсэн хүнийг хамааруулан ойлгоно.

15. Мөн зүйл заалтын "хоршоонд элсэнэ" гэдгийг энэ зүйлд заасан этгээд хоршооны гишүүнээр элсэх хүсэл зоригийн илэрхийллээ өргөдөл хэлбэрээр гаргаж, түүний үндсэн дээр тухайн этгээдийг хоршоонд элсүүлэхээр хоршооны бүх гишүүдийн хурлаар шийдвэрлэж, хоршооны дүрэмд заасны дагуу энэ тухай шийдвэр гарснаар хоршоонд элссэн гэж үзнэ.

Гишүүнээр элссэн шийдвэр гарсан үеэс эхлэн хоршооны гишүүний эрх, үүрэг, тэдгээрийн дотор хоршооны үйл ажиллагаанд оролцох, хоршооны эд хөрөнгийн зохих хувийг өмчлөх эрх тус тус үүснэ.

16. Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 11-д заасан "өрсөлдөгч бус хоршоо" гэж Хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-т заасан үйл ажиллагаанаас тухайн хоршоотой ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэггүй хоршоог хэлнэ.

Харин ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг, түүний үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаа нь адилхан, нутаг дэвсгэрийн хувьд өрсөлдөөнд орох боломжтой хоршоог "тухайн хоршоотой өрсөлдөх хоршоо" гэнэ.

Хоршооны гишүүн нь өрсөлдөх хоршоог өөрөө байгуулсан, хувь хөрөнгө нийлүүлсэн, түүнээс хөрөнгө авч хоршоондоо нийлүүлсэн нь Хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-т заасны дагуу түүнийг хоршооны гишүүнээс хасах үндэслэл болно.

17. Хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасан "хоршооны эд хөрөнгийн зохих хувийн өмчлөгч болох" гэж хоршооны гишүүн уг хоршоонд нийлүүлсэн хувь хөрөнгөө болон бусад хөрөнгийг хоршооны жилийн ашгаас гишүүнд ногдох хувьцаа алдагдлыг хасч тооцсон хэмжээгээр өмчилж, тэдгээрийг хууль болон хоршооны дүрэмд заасны дагуу худалдах, бэлэглэх, хандивлах зэргээр захиран зарцуулах, хуваарилсан орлогоос хүртэх, өвлүүлэх зэрэг эрх эдлэхийг хэлнэ.

18. Хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-д заасан "хоршооны гишүүн хууль, дүрэмд заасан үүргээ зөрчсөн" гэдэгт хоршооны гишүүн нь Хоршооны тухай хууль тогтоомжоор болон өөрийн хоршооны дүрэмд заасан үүргээ зөрчсөн явдлыг хамааруулна.

Хоршооны гишүүн үүргээ зөрчсөнөөс тухайн хоршооны хэвийн үйл ажиллагаа алдагдсан, түүнд бага бус хэмжээний хохирол учирсан, явуулбал зохих үйлдвэрлэл үйлчилгээ тасалдсан, түүнчлэн тухайн гишүүний оролцоотойгоор явагддаг үйлдвэрлэл үйлчилгээг зогсоох буюу өөрчлөхөд хүргэсэн зэрэг үр дагавар бий болсон явдал нь түүнийг хоршооны гишүүнээс хасах үндэслэл болж болно.

Түүнчлэн хоршооны гишүүн хууль, дүрэмд заасан үүргээ зөрчсөн үндэслэлээр түүнийг

гишүүнээс хасах тухай тэргүүлэгчдийн сануулга авсны дараа уг зөрчлийг дахин гаргасан тохиолдолд Хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-т заасны дагуу гишүүнийг хоршооны гишүүнээс хасна.

19. Хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д заасан "хоршооны гишүүн өөрийн оруулсан хувь хөрөнгийг бичгээр хийсэн гэрээний дагуу өөр гишүүнд хэдийд ч шилжүүлж болно" гэдгийг хоршооны гишүүн нь өөрийн оруулсан хувь хөрөнгөө бүрэн буюу зарим хэсгийг тухайн хоршооны бусад гишүүддээ бэлэглэх, худалдах, төлбөрт өгөх зэргээр бичгээр гэрээ байгуулах замаар шилжүүлж болно гэж ойлгоно. Харин тус хоршооны гишүүн бус этгээдэд шилжүүлэх асуудал энэ заалтад хамаарахгүй.

Хоршооны гишүүн өөрийн оруулсан хувь хөрөнгийг гишүүн бус этгээдэд шилжүүлэх зайлшгүй шаардлага бий болсон бол тухайн этгээд Хуулийн 13 дугаар зүйлд заасан журмын дагуу уг хоршооны гишүүнээр элсэж, бүртгэх байгууллагад бүртгүүлсний дараа түүнд хоршооны гишүүн өөрийн хувь хөрөнгөө шилжүүлж болно.

20. Хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан "өв залгамжлагч нь хоёр түүнээс дээш байвал гишүүнчлэлийн асуудлыг шийдвэрлэх хүртэл тэдгээр нь саналын нэг эрхтэй" гэдгийг хоршооны гишүүн нас барсны дараа түүний эд хөрөнгийн эрхийг өв залгамжлагч хэд хэдэн этгээд байвал тэдгээрийн гишүүнчлэлийн асуудлыг хоршооны бүх гишүүдийн хурлаар шийдвэрлэж, уг шийдвэрийг бүртгэх байгууллагад бүртгүүлэх хүртэл хугацаанд өв залгамжлагчид саналын нэг эрхийг дундаа эдэлнэ гэж ойлгоно.

21. Хуулийн 23 дугаар зүйлийн 23.4.3-т заасан "тэргүүлэгчид болон хяналтын зөвлөлийн гишүүнийг хоршооны гишүүнээс хасах" гэдгийг Хуулийн 18 дугаар зүйлд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэрлэнэ.

22. Хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3-т заасан "гишүүдийн гуравны нэгээс доошгүй хувийн саналаар бүх гишүүдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно" гэдэг нь хоршооны нийт гишүүдийн 33.3 хувиас доошгүй хувийн саналаар хурал зарласан бэйх бөгөөд уг санал бүх гишүүдийн хурлыг хуралдуулах үндэслэл, шалтгааныг зааж, уг санал гаргахад оролцсон гишүүн бүр гарын үсгээ зурсан баримт бичиг гарснаар хурлыг зарласанд тооцно. Мөн бүх гишүүдийн ээлжит бус хурлыг хуралдуулах товыг тогтоож, хуралд хүрэлцэн ирэх боломжтой хугацааны өмнө зарласан саналыг бүх гишүүдэд хүргүүлсэн байна.

23. Хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6-д заасан "бүх гишүүдийн хурлыг яаралтай зарлан хуралдуулна" гэдэг нь хоршооны тэргүүлэгчид үйл ажиллагаагаа явуулахгүй байна гэсэн үндэслэлээр бүх гишүүдийн хурлыг хяналтын зөвлөлөөс

зарласан, эсхүл бусад гишүүдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай гишүүдийн саналаар тавигдсан шаардлагыг биелүүлээгүй буюу саатуулсан тэргүүлэгчид, хяналтын зөвлөлийн гишүүдийг өөрчлөх тухай асуудлыг хэлэлцэхээр бүх гишүүдийн хурал зарлан хуралдуулахыг хэлнэ. Энэ хурлыг хоршооны нэг буюу хэд хэдэн гишүүн өөрсдийн сонгосон хугацаанд зарлах эрхтэй боловч гишүүд хуралдаа хүрэлцэн ирэх боломжийг харгалзах бөгөөд тухайн хугацаанд Хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасан 30 хоног хамаарахгүй. Хоршооны бүх гишүүдэд зарыг хүргүүлэх буюу албан ёсоор мэдэгдэнэ.

Яаралтай зарлан хуралдуулсан бүх гишүүдийн хурал Хуулийн 23 дугаар зүйлийн 23.5-д заасны дагуу хоршооны гишүүдийн дийлэнх олонх хүрэлцэн ирснээр хүчин төгөлдөр болно.

24. Хуулийн 27 дугаар зүйлийн 27.4-т заасан "тэргүүлэгчид хоршоог төлөөлөх эрхийг тэдгээрийн олонхийн саналаар хэрэгжүүлнэ" гэдгийг хоршоог төлөөлөх эрх хамтын зарчимд үндэслэдэг тул тэргүүлэгчдийн олонхын буюу 50-иас дээш хувийн саналаар албан ёсны шийдвэр гарсан тохиолдолд хэрэгжинэ гэж ойлгоно.

25. Хуулийн 27 дугаар зүйлийн 27.8-д заасан "гишүүдэд олгох зээлийн дээд хэмжээг тогтооно" гэдэг нь хоршооны нэг гишүүнд олгох зээлийн хэмжээний дээд хязгаарыг заасан шийдвэр гаргахыг хэлнэ.

26. Хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т заасан "хоршооны хөрөнгөөр төлбөр хийсэн" гэдэг нь хоршооны тэргүүлэгчид нь хууль, дүрэмд заасан эрх хэмжээгээ хэтрүүлж, хоршооны хариуцвал зохих үүрэг, төлбөрт үл хамаарах зүйлд хоршооны хөрөнгөөр төлбөр хийсэн байхыг ойлгоно.

27. Хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.3-т заасан "хоршоог төлбөрийн чадваргүй болгосон буюу дампууруулах үндэслэл бүрдүүлсэн" гэдэгт хоршооны тэргүүлэгчдээс хууль тогтоомж, хоршооны дүрэм зөрчиж гаргасан шийдвэр, үйл ажиллагаанаас хоршоонд бодитой хохирол учирсан, төлбөрийн чадваргүй болгосон буюу дампууруулах үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд энэ явдалд тэргүүлэгчид гэм буруутай болох нь тогтоогдсон байхыг хамааруулна.

28. Хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.4-т заасан "хоршооны хөрөнгөөс зээл олгосон" гэдгийг хоршооны тэргүүлэгчид нь хууль болон тухайн хоршооны дүрэмд заагаагүй үндэслэлээр хоршооны хөрөнгөөс хоршооны гишүүн болон бусад этгээдэд зээл олгосон байхыг хэлнэ.

29. Хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т заасан "хоршоог төлөөлөх итгэмжлэлд гарын үсэг зурна", мөн зүйлийн 31.3-т заасан "гүйцэтгэх захирлыг томилж, түүнтэй гэрээ байгуулах" эрхийг хоршооны дарга хэрэгжүүлэхдээ Хуулийн

27 дугаар зүйлийн 27.4 дэх заалт, энэ тогтоолын 24 дэх заалтын дагуу гарсан хоршооны тэргүүлэгчдийн албан ёсны шийдвэрийг үндэслэнэ.

30. Хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3-т заасан **"хууль, дүрэмд зааснаас өөр үйл ажиллагаа явуулсан"** гэдэгт хоршоо нь Хоршооны тухай хууль тогтоомж, өөрийн дүрмээр тодорхойлж, улсын бүртгэлд бүртгүүлсэн зорилго, үйл ажиллагааныхаа төрлийг зөрчиж, түүнээс өөр төрлийн үйл ажиллагаа явуулсан байхыг ойлгоно.

Хоршоо эрхлэх үйл ажиллагааныхаа төрлийг өөрчлөх, нэмэгдүүлэх болон хорогдуулах, өөр төрлийн үйл ажиллагаа явуулах тохиолдолд Хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, дүрэмдээ нэмэлт, өөрчлөлт оруулж, улсын бүртгэлд бүртгүүлсэн байвал зохино.

31. Хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.4-т заасан **"хуулийг удаа дараа буюу ноцтой зөрчсөн"** гэсний **"удаа дараа зөрчсөн"** гэдгийг Монгол улсын хууль тогтоомжийг хоршоо нь гурав буюу түүнээс дээш зөрчсөнийг; **"ноцтой зөрчсөн"** гэдгийг хоршоо нь эд хөрөнгөө хуурамчаар бүрдүүлсэн, дүрэм, түүгээр тодорхойлсон зорилго нь Монгол улсын хууль тогтоомжид нийцээгүй, тусгай зөвшөөрөл шаардагдсан эсхүл хориотой үйлдвэрлэл, үйлчилгээг хууль бусаар эрхэлсэн, тайлан тэнцэл, санхүүгийн бүртгэлээ санаатай будлиантуулж, татвараас зайлсхийсэн, хүнсний аюулгүй байдал болон байгаль орчны аюулгүй байдлыг санаатай зөрчсөн буюу хууль, тогтоомжийг бусад хэлбэрээр зөрчсөн нь төр, иргэд, бусад хуулийн этгээдэд их хэмжээний хохирол учруулсан ба учруулж болох байсан зэргийг ойлгох бөгөөд эдгээр нь хоршоог татан буулгах үндэслэл болно.

32. Хуулийн 45 дугаар зүйлийн 45.1-д заасан **"хоршооны үйл ажиллагаа дуусгавар болсноос хойш гишүүдийн хоршоонд заавал нийлүүлэх хувь хөрөнгийн хэмжээ, нөхөх харуцлагыг нэмэгдүүлж үл болно"** гэдгийг Хуулийн 38, 39 дүгээр зүйлд зааснаар хоршоог татан буулгах тухай шийдвэр гарсан үеэс хойш гишүүдийн заавал нийлүүлэх хувь хөрөнгийн хэмжээ, нөхөх харуцлагыг ямар нэгэн үндэслэлээр нэмэгдүүлж болохгүй гэж ойлгож хэрэглэнэ.

33. Хуулийн 46 дугаар зүйлийн 46.2-т заасан **"хоршоонд нэхэмжлэл гаргах эрхтэй этгээд ийнхүү нэхэмжлэл гаргах боломжийг нохцолд байгаа"** гэдэгт татан буугдаж байгаа хоршооноос авах өр төлбөртэй холбоотой нэхэмжлэл гаргах эрхтэй этгээд болон түүний төлөөлөгч нь өвчилсөн, хугацаат цэргийн жинхэнэ албанд татагдсан болон батлан хамгаалах, түүнчлэн иргэний үүргээ гүйцэтгэхээр дайчлагдсан, баривчлагдсан, хоригдсон эсхүл ял эдэлж байгаа, оршин суугаа газраасаа өөр газар удаан хугацаагаар өвсөн,

байгалийн гэнэтийн аюул /гал, ус, газар хөдлөлт зэрэг/ учирсан, эсхүл халдварт өвчний хорио цээрийн дэглэм тогтоогдсон зэргээс шалтгаалан нэхэмжлэл гаргаагүйг хамааруулна.

34. Хуулийн 46 дугаар зүйлийн 46.3-т заасан **"төлбөрийн талаар маргаантай бол тухайн этгээдэд ногдох хэсгийг тусгаарласны дараа үлдсэн хөрөнгийг гишүүдэд хуваана"** гэдгийг хоршоог татан буулгах явцад түүний үүрэг гүйцэтгүүлэгчийн нэхэмжилсэн төлбөрийн талаар маргаантай бол маргааныг шүүх, арбитр шийдвэрлэж, шийдвэр нь хүчин төгөлдөр болох хүртэл тухайн этгээдийн төлбөрийг төлөхөд хүрэлцэх хэсгийг тусгаарласны дараа үлдсэн хөрөнгийг гишүүдэд хуваана гэж ойлгоно.

35. Хуулийн 47 дугаар зүйлийн 47.5-д заасан **"эд хөрөнгийг хуваарилахыг хориглох, эсхүл хуваарилах харьцааг өөрөөр тогтоож болно"** гэснийг хоршоог татан буулгахад үүрэг гүйцэтгүүлэгчдийн нэхэмжлэл хангах ажиллагаа дууссаны дараа үлдсэн эд хөрөнгийг гишүүдэд хуваарилахдаа хоршооны жилийн орлогоос хувь хүртэх журам, заавал оруулах болон илүү оруулсан хувь хөрөнгө, хөдөлмөрийн оролцоо, түүний хэлбэр /эд хөрөнгө, бэлэн мөнгө, ажил үйлчилгээ, оюуны өмч/ зэргийг харгалзан зарим гишүүнд эд хөрөнгө хуваарилахыг хориглох буюу хуваарилах харьцааг хоршооны дүрэмд тухайлан тусгаж болно гэж ойлгоно.

36. Хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1.2-т заасан **"дүрэмд зааснаас өөр үйл ажиллагаа явуулсан"** гэдэгт Хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-т болон өөрийн дүрэмд зааснаас, мөн улсын бүртгэлд бүртгүүлснээс өөр төрлийн үйл ажиллагаа эрхлэн явуулсан байхыг хэлнэ.

Энэ тохиолдолд гэм буруутай этгээдэд шүүгч захиргааны шийтгэл ногдуулахдаа дүрэмд зааснаас өөр үйл ажиллагааг хэдэн удаа явуулсан, уг зөрчил нь байнгын шинэжтэй эсэхийг үл харгалзан олсон орлогыг хурааж, хоршоог 100000-250000 төгрөг хүртэл торгоно.

Уг үйл ажиллагааны улмаас Хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3-т заасны дагуу хоршоог татан буулгаж байгаа бол түүнийг татан буулгах шийдвэр гаргасан шүүх уг захиргааны шийтгэлийг ногдуулна.

37. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан "Хоршооны тухай Монгол улсын хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай" Улсын Дээд шүүхийн 2000 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн 2 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ	С.БАТДЭЛГЭР
ШҮҮГЧ	А.ДОРЖГОТОВ

2007 оны 06 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 27

 Улаанбаатар
хот

КОМПАНИЙН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Компанийн тухай Монгол улсын хуулийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Компанийн тухай хууль /цаашид Хуулийн гэх/-ийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан **"хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулагдсаны дараа хувьцаа эзэмшигчдийн тоог хязгаарлахгүй"** гэдгийг хязгаарлагдмал хариуцлагатай компани улсын бүртгэлд бүртгүүлж, дүрэмд заасан үйл ажиллагаа явуулж эхэлсэн үеэс эхлэн энэ зүйлд заасан "компанийг үүсгэн байгуулагчдын тоо 50-аас дээшгүй байна" гэсэн хязгаарлалт компанийн гишүүдийн тоонд хамаарахгүй гэж ойлгоно.

2. Мөн зүйлийн 5.2-т заасан **"...хувьцаат...захиалга..."** гэдгийг нээлттэй захиалга гэсэн утгаар ойлгож хэрэглэнэ.

3. Мөн зүйлийн 5.3-т заасан **"эзэмшиж байгаа хувьцааныхаа тоонд хувь тэнцүүлэн"** гэдэг нь бусад хувьцаа эзэмшигчийн хувьцааг худалдан авах гэж байгаа хоёр ба түүнээс дээш хувьцаа эзэмшигч байгаа тохиолдолд хэн хэдэн ширхэг хувьцааг тэргүүн ээлжинд авч болохыг тэдгээрийн эзэмшдэг хувьцааны хувиас тооцохыг хэлнэ.

Харин энэ тосроог хувьцаа худалдан авах дээд хязгаар гэж ойлгож болохгүй.

4. Мөн зүйл заалтын **"гурав дахь этгээдэд санал болгох үнээр... худалдан авах эрхтэй"** гэдгийг хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшиж буй хувьцааг худалдах нөхцөлд хувьцаа эзэмшигч биш этгээдэд худалдах үнийн саналыг бусад хувьцаа эзэмшигчдэд эхлээд гаргах үүрэгтэй ба энэ үнээр тэргүүн ээлжинд худалдахыг бусад хувьцаа эзэмшигч шаардах эрхтэй гэж ойлгоно.

Мөн зүйлийн 5.6-д зааснаар хувьцаа эзэмшигчийн санал болгосон дээрх үнээр бусад хувьцаа эзэмшигч болон компани хувьцааг худалдан авахаас татгалзсан бол хувьцаа эзэмшигч нь үнийн саналыг тодорхойлсон мэдэгдэлд зааснаас доошгүй үнээр хувьцаа эзэмшигч бус этгээдэд хувьцааг худалдах эрх, үүргийг бий болгоно.

5. Мөн зүйлийн 5.5-д заасан **"тогтоосон хугацаанд"** гэдэг нь хувьцааг худалдах тухай мэдэгдэлд заасан хугацааг, **"бүрэн эдлээгүй тохиолдолд"** гэдэг нь хувьцаа эзэмшигч хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхээсээ бүхэлд нь татгалзсан, эсхүл худалдагдаж буй хувьцааны заримыг нь худалдан авахаар давуу эрхээ эдэлсэн байхыг тус тус хэлнэ. Энэ тохиолдолд зарагдаж буй хувьцааг бүгдийг нь, эсхүл хувьцаа эзэмшигчийн худалдаж аваагүй үлдэх хэсгийг худалдан авах эрх компанид шилжинэ.

6. Хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т заасан **"өрийг хариуцахгүй"** гэдгийг толгой компани нь хараат болон охин компанийн үйл ажиллагаанд зөвхөн хувьцаа эзэмшигчийн эрхээр оролцдог, эдгээр компаниуд нь бие даасан хуулийн этгээдүүд тул охин болон хараат компани толгой компанийн өрийг хариуцах үндэслэлгүй, харин толгой компани нь зөвхөн гэрээнд заасан тохиолдолд хараат болон охин компанийн өрийг хариуцна гэж ойлгоно.

7. Хуулийн 7 дугаар зүйлийн 7.6-д заасан **"компани нь өөрийн салбар, төлөөлөгчийн газрын хүлээх үүргийг хариуцна"** гэдэг нь компанийн салбар, төлөөлөгчийн газар нь компанийн нэрийн өмнөөс, түүний баталсан дүрэм, журмын дагуу үйл ажиллагаагаа явуулдаг, эд хөрөнгө нь компанийн тайлан тэнцэлд тусгагддаг тул салбар, төлөөлөгчдийн газрын хүлээх эрх зүйн харилцааны үүргийг компани хариуцна.

8. Мөн зүйлийн 7.7-д заасан **"компаниас олгосон итгэмжлэл"** гэдэг нь Иргэний хуульд заасан журмын дагуу олгогдсон, мөн Хуулийн 64 дүгээр зүйлийн 64.2-т заасан шаардлагыг хангасан байна. Энэ итгэмжлэлийн дагуу салбар, төлөөлөгчийн газрын эрх баригч нь үйл ажиллагаа явуулах бөгөөд эдгээр үйл ажиллагаатай холбоотой маргаанд компанийг шүүхэд төлөөлөх эрхтэй.

9. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан **"компанийн хүлээсэн үүргээ биелүүлэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй"** гэдгийг компани эрхлэх үйл ажиллагаагаа дүрмээр хязгаарласан бөгөөд уг хязгаарлалтын талаар гуравдагч этгээдэд анхааруулж, танилцуулснаас бусад тохиолдолд хуулийн дагуу үйл ажиллагаа явуулсан бусад этгээдийн өмнө хүлээсэн үүргээс компанийг энэхүү хязгаарлалт чөлөөлөхгүй гэж ойлгоно.

10. Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д заасан **"бүх эд хөрөнгө"** гэдэгт компанийн санхүүгийн тайлан тэнцэл, бүртгэлд байгаа өөрийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх тус тус хамаарна.

11. Мөн зүйлийн 9.2-т заасан **"компани нь хувьцаа эзэмшигчдийн хүлээх үүргийг хариуцахгүй"** гэдэг нь хувьцаа эзэмшигчдийн компаниас гадуурх үйл ажиллагааны улмаас бий болсон үүргийг компани өөрийн эд хөрөнгөөр хариуцахгүй гэж ойлгоно.

12. Мөн зүйлийн 9.3-т заасан **"эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээнэ"** гэж компанийн хүлээх үүргийг гишүүн өөрийн өмчлөлийн эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхээр хариуцахгүй бөгөөд гагцхүү компанид оруулсан хөрөнгө буюу эзэмшиж байгаа хувьцаагаар хариуцлага хүлээхийг хэлнэ.

13. Мөн зүйлийн 9.4-т заасан **"өөрийн хөрөнгө"** гэдэгт хохирол учруулсан этгээдийн өмчлөлийн эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрх хамаарна.

14. Мөн зүйлийн 9.5-д заасан **"компанийн өр төлбөрийг давхар хариуцна"** гэдэг нь компанид оруулсан хувь нийлүүлэгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь компанийн хөрөнгөд бүртгэгдэн, тайлан тэнцэлд тусгагдаж, түүний хувийн эд хөрөнгөөс зааглагдсан байх ёстой боловч ийнхүү зааглаагүй тохиолдолд компанийн төлбөрийг барагдуулахад хувь нийлүүлэгчийн бүх эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь компанийн өөрийн хөрөнгөд тооцогдон түүгээр компанийн хүлээх хариуцлагыг нөхөн төлнө гэж ойлгоно.

15. Хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д заасан **"захиалсан нийт хувьцааны 30 хувьтай тэнцэх төлбөрийг захиалгын хугацаа дууссанаас хойш ажлын 30 хоногийн дотор хийнэ"** гэдгийг хувьцаат компани үүсгэн байгуулахад хамааруулан ойлгоно.

16. Мөн зүйлийн 13.6-д заасан **"хуулиар тогтоосон өөрийн хөрөнгийн доод хэмжээнд хүрсэн"** гэж Хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д заасан хэмжээнд хүрсэн байхыг хэлнэ.

17. Мөн зүйлийн 13.8-д заасан **"хамтран ажиллах гэрээ"** нь Иргэний хуулийн дөчин наймдугаар бүлэгт заасан журмаар зохицуулагдах бөгөөд түүнийг үүсгэн байгуулах гэрээ гэж үзэхгүй.

18. Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т заасан **"саналын тэнцүү эрх"** гэдэгт үүсгэн байгуулагчийн компанид оруулах хөрөнгийн дүнгээс хамаарахгүйгээр үүсгэн байгуулах хуралд тэдгээрийн гаргасан санал адил эрхтэй байхыг ойлгоно. Үүсгэн байгуулагчид саналын

зөрөлдөөнгүйгээр тохиролцсон бол саналын тэнцүү эрхийг хэрэгжүүлэхгүй байж болно.

19. Мөн зүйлийн 14.4-т заасан **"дийлэнх олонхын санал"** гэдэг нь хуралд оролцсон үүсгэн байгуулагчдын гуравны хоёр буюу 66.6-иас дээш хувийн саналаар шийдвэр гаргахыг хэлнэ.

20. Мөн зүйлийн 14.7-д заасан **"эд хөрөнгийн үнийг ...санал нэгтэй шийдвэрлэнэ"** гэдэг нь компанийн үүсгэн байгуулагчид нь мөнгөн бус хэлбэрээр буюу эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр хөрөнгө оруулж байгаа бол түүний үнийг үүсгэн байгуулах хуралд оролцогчид 100 хувийн саналаар тогтооно гэж ойлгоно. Хэрэв үүсгэн байгуулах хуралд оролцогчид санал зөрвөл тухайн эд хөрөнгийн үнийг шийдвэрлээгүй гэж үзнэ.

21. Хуулийн 17 дугаар зүйлийн 17.8-д заасан **"...бүртгэснээр хүчин төгөлдөр болно"** гэдэг нь компанийн дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлт, шинэчлэн найруулсан дүрмийг бүртгэх байгууллага Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаар улсын бүртгэлд бүртгэснээр хүчин төгөлдөр болж, мөрдөгдөнө гэж ойлгоно.

22. Хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасан **"шүүх компанийг хуваах, тусгаарлах шийдвэр гаргаж болно"** гэдэг нь тухайн компани, түүний үүсгэн байгуулагч болон хувьцаа эзэмшигчдийн хүсэл зоригоос үл хамааран гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд шүүх компанийг хуваах, тусгаарлах шийдвэр гаргахыг хэлнэ. Харин энэ зүйлийн 18.1-д зааснаар компанийг хуваах, тусгаарлах асуудлаар гарсан маргааныг шүүх ердийн журмаар шийдвэрлэнэ.

23. Хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4-т заасан **"шинээр үүссэн компани бүр бусад компанийнхаа өмнөөс давхар хариуцлага хүлээнэ"** гэдэг нь компанийг хуваах тухай гэрээнд бусдад төлөх өр төлбөрийг хэрхэн хариуцах талаар тусгайлан заагаагүй бол компанийг хуваахад шинээр үүссэн компаниуд нь Иргэний хуулийн 242 дугаар зүйлд зааснаар хамтран үүрэг гүйцэтгэгчийн хэмжээнд хариуцлага хүлээхийг хэлнэ.

24. Хуулийн 26 дугаар зүйлийн 26.4-т заасан **"...шүүх хуралд төлөөлөн оролцоно"** гэдгийг компанийг татан буулгах комисс нь татан буугдаж байгаа компанийн нэрийн өмнөөс түүнийг төлөөлөн хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагаанд оролцоно гэж ойлгоно.

25. Хуулийн 27 дугаар зүйлийн 27.3, 27.6-д заасан **"зээлдүүлэгчдэд бичгээр мэдэгдэх үүрэгтэй"** гэдэгт татан буулгах комисс нь компанийг татан буулгах, нэхэмжлэл гаргах журам, хугацааг харилцагч банк, санхүүгийн байгууллага болон

аливаа үүрэг гүйцэтгүүлэгчид мэдэгдэхийг хамааруулна.

26. Мөн зүйлийн 27.10-т заасан "...шүүх тусгайлан шийдвэрлээгүй бол гаргасан аливаа нэхэмжлэлийг хүлээн авахгүй" гэдгийг шүүхийн шийдвэр гараагүй үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг татан буулгах комисс хүлээн авахаас татгалзана гэж ойлгоно.

27. Хуулийн 33 дугаар зүйлийн 33.5-д заасан "хувьцаа бүр саналын нэг эрхтэй", 33.6-д заасан "хувьцаа хуваагдахгүй..." гэдгийг компанийн энгийн хувьцаа нэг бүр нь саналын нэг эрхтэй байх бөгөөд уг саналын эрхийг хуваан эзэмшиж болохгүй гэж ойлгоно. Энэ нь хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож, хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх, давуу эрхийн хувьцааны ашиг хуваарилсны дараа эзэмшиж байгаа хувьцаандаа тогтоосон хэмжээний ногдол ашиг авах, компани татан буулгах үед хувь хүртэх, хувьцаа нэмж гаргахад тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг тодорхойлох үндэслэл болно.

28. Хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.3-т заасан "...хувьцааны татан буулгалтын үнэ" гэдгийг компанийг татан буулгах үеийн хувьцааны үнэ гэж ойлгоно.

29. Хуулийн 42 дугаар зүйлийн 42.4-т заасан "өөр компаниас тусгайлан гаргасан баталгаа..." гэж Иргэний хуулийн 234 дүгээр зүйлд зааснаар гаргасан баталгааг хэлнэ.

30. Хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т заасан "компанийг" гэдгийг хязгаарлагдмал хариуцлагатай компани гэж ойлгож хэрэглэнэ.

31. Хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.11-д заасан "их хэмжээний хэлцлийг батлах" гэдэг нь Хуулийн арван нэгдүгээр бүлэгт заасан их хэмжээний ямар хэлцэл хийж болохыг хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэн батлахыг хэлнэ. Харин хувь нийлүүлэгчдийн хурлаар батлагдсан их хэмжээний хэлцэл лийх зөвшөөрлийг Хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16-д заасны дагуу хэлцэл хийх этгээдэд төлөөлөн удирдах зөвлөл, төлөөлөн удирдах зөвлөл байхгүй бол хуулийн 85 дугаар зүйлийн 85.1.-д зааснаар хувь нийлүүлэгчдийн хурал олгоно гэж ойлгож хэрэглэнэ.

32. Мөн зүйлийн 63.1.12-т заасан "сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах" гэдэг нь Хуулийн арванхоёрдугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй ямар хэлцлийг хийж болох талаар хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэн батлахыг хэлнэ. Харин хувь нийлүүлэгчдийн хурлаар батлагдсан сонирхлын зөрчилтэй хэлцлийг хийх зөвшөөрлийг хэлцэл хийвэл зохих этгээдэд

Хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17-д заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөл олгоно.

33. Хуулийн 64 дүгээр зүйлийн 64.4-т заасан "саналын олонхоор шийдвэрлэнэ" гэдгийг Компанийн тухай хууль болон дүрэмд олонхийн хэмжээг ердийн олонхоос дээш байхаар заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх зөвлөл/-ийн гишүүдийг сонгохоос бусад асуудлыг хуралд оролцож байгаа хувь нийлүүлэгчдийн саналын эрхийн 50-иас дээш хувийн саналаар шийдвэрлэнэ гэж ойлгоно.

Харин мөн зүйл, заалтын "хамгийн олон санал авсан хүнийг сонгоно" гэдэг нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол түүний төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн гишүүдэд нэр дэвшигчээс хуралд оролцож байгаа хувь нийлүүлэгчдийн хамгийн олон санал авсан хүнийг сонгогдсонд тооцно гэж ойлгоно.

34. Хуулийн 64 дүгээр зүйлийн 64.5-д заасан "саналын дийлэнх олонхоор шийдвэрлэнэ" гэдэг нь хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувь нийлүүлэгчдийн саналын эрхийн гуравны хоёроос дээш саналаар шийдвэрлэхийг хэлнэ. Харин энэ заалтын "шийдвэрлэх саналын тоог ... дээгүүр тогтоож болно" гэдэг нь компанийн дүрмээр асуудлыг шийдвэрлэх саналын эрхийн хувийг саналын эрхийн гуравны хоёроос дээш хувиар тогтоож болно гэж ойлгож хэрэглэнэ.

35. Хуулийн 68 дугаар зүйлийн 68.1-д заасан "...хөндлөнгийн гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх..." гэдэг нь тооллогын комисст компанийн хувь нийлүүлэгч биш, хэлэлцэх асуудалд ямар нэгэн сонирхолгүй, сонирхлын зөрчилтэй хүмүүстэй холбоогүй этгээдийг томилохыг хэлнэ.

36. Хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д заасан "...итгэмжлэлийн үндсэн дээр өөр этгээдээр төлөөлүүлэн оролцож болно" гэдэг нь Иргэний хуулийн 63 дугаар зүйлд заасны дагуу төлөөлөгчөөр дамжуулан хувь нийлүүлэгчдийн хуралд оролцохыг ойлгоно.

37. Мөн зүйлийн 69.5-д заасан "...төлөөлөн оролцох эрхийг Иргэний хуульд заасны дагуу баталгаажуулсан" гэж Иргэний хуулийн 63, 64 дүгээр зүйлд заасны дагуу төлөөлөгчийн бүрэн эрхийг итгэмжлэлээр олгосон байхыг хэлнэ.

38. Хуулийн 70 дугаар зүйлийн 70.7-д заасан "түрүүчдийн хуралд ирүүлсэн саналыг хийшлэгдсэн хурлын ирц, санал хураалтын дүнд тооцно" гэдэг нь компанийн хурал хойшлогдсон тохиолдолд хувь нийлүүлэгчээс Хуулийн 69 дүгээр

зүйлийн 69.3-т заасны дагуу саналын хуудсаар ирүүлсэн саналыг тухайн этгээд дараагийн хуралд өөрөө ирээгүй тохиолдолд тухайн асуудлаарх хурлын ирц, санал хураалтын дүнд оруулан тооцно гэж ойлгоно.

39. Хуулийн 78 дугаар зүйлийн 78.3-т заасан "...даргын томилсон"..." төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрлэсэн..." гэдэг нь төлөөлөн удирдах зөвлөлийн даргын түр эзгүйд түүний үүргийг төлөөлөн удирдах зөвлөлийн аль нэг гишүүн орлон гүйцэтгэх бөгөөд энэ талаар даргын тушаал, эсхүл төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол гарсан байхыг хэлнэ.

40. Хуулийн 79 дүгээр зүйлийн 79.2-т заасан "төлөөлөн удирдах зөвлөл эчнээ санал хураалтаар шийдвэр гаргах" гэдгийг төлөөлөн удирдах зөвлөл заавал хурлаар хэлэлцэх шаардлагагүй, компанийн шуурхай удирдлагыг

хэрэгжүүлэх асуудлаар зөвлөлийн гишүүдийн саналыг Хуулийн 73 дугаар зүйлд заасан журмаар хурааж, тогтоол гаргахыг ойлгоно.

41. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан "Нөхөрлөл, компанийн тухай Монгол улсын хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай" Улсын Дээд шүүхийн 1997 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 380 дугаар тогтоолын 1, 15-32 дугаар заалтыг бүхэлд нь, мөн тогтоолын 2, 3, 4, 5, 6, 7, 8 дахь заалтаас "...компани..." гэсэн үгийг, түүнчлэн "Нөхөрлөл, компанийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай" Улсын Дээд шүүхийн 1998 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 474 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР

ШҮҮГЧ

А.ДОРЖГОТОВ

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

1978 ОНЫ ПРОТОКОЛООР ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН ДАЛАЙГ ХӨЛӨГ ОНГОЦНООС БОХИРДУУЛАХААС СЭРГИЙЛЭХ ТУХАЙ 1973 ОНЫ ОЛОН УЛСЫН КОНВЕНЦИД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ 1997 ОНЫ ПРОТОКОЛ*

Энэхүү протоколд оролцогч талууд, Далайг хөлөг онгоцноос бохирдуулахаас сэргийлэх тухай 1973 оны олон улсын конвенцийн 1978 оны протоколд оролцогч талууд болж, агаарыг хөлөг онгоцноос бохирдуулахаас урьдчилан сэргийлэх болон түүнд хяналт тавих шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрч,

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх тухай Хүрээлэн буй орчин, хөгжлийн тухай Риогийн тунхаглалын 15 дугаар зарчмыг эргэн санаж,

энэхүү зорилгод 1978 оны протоколоор өөрчлөлт оруулсан Далайг хөлөг онгоцноос бохирдуулахаас сэргийлэх тухай 1973 оны конвенцид нэмэлт өөрчлөлт оруулах 1997 оны протоколыг байгуулснаар хүрч болох юм гэдгийг харгалзан үзэж,

дараахь зүйлийг хэлэлцэн тохиров:

1 дүгээр зүйл

Нэмэлт өөрчлөлт оруулах баримт бичиг

Энэхүү протоколоор нэмэлт өөрчлөлт оруулах баримт бичиг нь 1978 оны протоколоор өөрчлөлт оруулсан Далайг хөлөг онгоцноос бохирдуулахаас сэргийлэх тухай 1973 оны конвенц (цаашид "Конвенц" гэх) болно.

2 дугаар зүйл

Конвенцийн 6 дугаар хавсралтын нэмэлт

Энэхүү протоколын хавсралтад тусгасан Агаарыг хөлөг онгоцноос бохирдуулахаас сэргийлэх тухай

зохицуулалт хэмээн нэрийдсэн VI хавсралтад нэмэлт оруулав.

3 дугаар зүйл

Нийтлэг үүргүүд

1. Энэхүү протоколд оролцогч талууд Конвенц болон энэхүү протоколыг хамтад нь нэг баримт бичиг мэтээр хэрэглэж тайлбарлана.
2. Энэхүү протоколоос хийх ишлэл бүр нь түүний хавсралтаас нэгэн зэрэг ишлэл хийсэн хэрэг болно.

4 дүгээр зүйл

Нэмэлт өөрчлөлт оруулах журам

Конвенцийн 16 дугаар зүйлийг 6 дугаар хавсралт болон түүний нэмэлт хавсралтуудад хэрэглэхдээ "Конвенцийн оролцогч талууд" гэсэн ишлэлийг уг хавсралтын дагуу үүрэг хүлээсэн оролцогч тал гэсэн утгатай ишлэл гэж үзнэ.

ТӨГСГӨЛИЙН ЗААЛТУУД

5 дугаар зүйл

Гарын үсэг зурах, соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах болон нэгдэн орох

1. Энэхүү протокол нь Далайн олон улсын байгууллагын (цаашид "Байгууллага" гэх) төв байранд 1998 оны 1 дүгээр сарын 1-ээс 1998 оны 12 дугаар сарын 31 хүртэл гарын үсэг зурахад нээлттэй бөгөөд түүнээс хойш нэгдэн ороход

* Далайг хөлөг онгоцноос бохирдуулахаас сэргийлэх тухай 1973 оны олон улсын конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1997 оны протокол -ыг соёрхон батлах тухай Монгол Улсын хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2007 оны 20 дугаарт нийтлэгдсэн.

нээлттэй байна. Зөвхөн Далайг хөлөг онгоцноос бохирдуулахаас сэргийлэх тухай 1973 оны олон улсын конвенцийн 1978 оны протоколын (цаашид "1978 оны протокол" гэх) хэлэлцэн тохирогч улсууд дараахь замаар илэрхийлснээр энэхүү протоколын талууд болж болно:

(a) соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх буюу батлах тухай тайлбаргүйгээр гарын үсэг зурах; эсхүл

(b) соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх буюу батлах нөхцөлтэйгөөр соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх буюу батлахаар гарын үсэг зурах; эсхүл (c) нэгдэн орох.

2. Соёрхон батласан, хүлээн зөвшөөрсөн, батласан буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг Байгууллагын ерөнхий нарийн бичгийн даргад (цаашид "Ерөнхий нарийн бичгийн дарга" гэх) хадгалуулахаар өгснөөр тэдгээр нь хүчин төгөлдөр болно.

6 дугаар зүйл

Хүчин төгөлдөр болох

1. Энэхүү протокол нь худалдааны хөлөг онгоцууд нь нийтдээ дэлхийн худалдааны хөлөг онгоцны нийт багтаамжийн 50-аас доошгүй хувийг эзлэх арван таваас доошгүй улс энэхүү протоколын 5 дугаар зүйлийн дагуу оролцогч тал болсноос хойш арван хоёр сарын дараа хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү протокол хүчин төгөлдөр болсноос хойш түүнийг соёрхон батласан, хүлээн зөвшөөрсөн, батласан буюу нэгдэн орсон тухай хадгалуулахаар өгсөн баримт бичгийн хувьд тийнхүү хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш гурван сарын дараа тэдгээр нь хүчин төгөлдөр болно.

3. Конвенцийн 16 дугаар зүйлийн дагуу энэхүү протоколд оруулсан нэмэлт өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн өдрөөс хойш хадгалуулахаар өгсөн соёрхон батласан, хүлээн зөвшөөрсөн, батласан буюу нэгдэн орсон тухай баримт бичиг нь нэмэлт өөрчлөлт оруулсан энэхүү протоколын хувьд хүчинтэй гэж үзнэ.

7 дугаар зүйл

Цуцлалт

1. Энэхүү протоколыг түүний оролцогч аль ч тал энэхүү протокол тухайн талын хувьд хүчин төгөлдөр болсноос таван жилийн дараа хэдий ч цуцалж болно.

2. Цуцлалт нь цуцлах тухай баримт бичгийг Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулахаар өгснөөр хүчин төгөлдөр болно.

3. Цуцлалт нь цуцлах тухай баримт бичгийг Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулахаар өгснөөс хойш арван хоёр сарын дараа, эсхүл түүнд тодорхойлж болох хэсэг хугацааны дараа хүчин төгөлдөр болно.

4. 1978 оны протоколыг түүний 7 дугаар зүйлд заасны дагуу цуцалснаар энэхүү протоколын энэ зүйлд заасны дагуу түүнийг мөн цуцалсан гэж үзнэ. Уг цуцлалт 1978 оны протоколын 7 дугаар зүйлд

заасны дагуу Протоколын цуцлалт хүчин төгөлдөр болсон өдөр мөн хүчин төгөлдөр болно.

8 дугаар зүйл

Хадгалах

1. Энэхүү протоколыг Ерөнхий нарийн бичгийн дарга (цаашид "Хадгалагч" гэх) хадгална.

2. Хадгалагч нь:

(a) энэхүү протоколд гарын үсэг зурсан буюу түүнд нэгдэн орсон улсуудад дараахь зүйлийг мэдээлнэ:

(i) гарын үсэг зурсан буюу соёрхон батласан, хүлээн зөвшөөрсөн, батласан буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар өгсөн тухай бүрийг тэдгээрийн он, сар, өдрийн хамт;

(ii) энэхүү протокол хүчин төгөлдөр болсон өдрийн тухай;

(iii) энэхүү протоколыг цуцалсан тухай аливаа баримт бичгийг хадгалуулахаар өгснийг тийнхүү өгсөн өдөр болон цуцлалт хүчин төгөлдөр болсон өдрийн хамт.

(b) энэхүү протоколд гарын үсэг зурсан буюу түүнд нэгдэн орсон бүх улсад энэхүү протоколын баталгаат хуулбарыг илгээнэ.

3. Энэхүү протокол хүчин төгөлдөр болмогц хадгалагч түүний баталгаат хуулбарыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн 102 дугаар зүйлд заасны дагуу бүртгүүлэх болон хэвлүүлэхээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хүргүүлнэ.

9 дүгээр зүйл

Хэл

Энэхүү протоколыг араб, хятад, англи, франц, орос болон испани хэлээр нэг хувь үйлдсэн бөгөөд эх бичвэр бүр нь адил хүчинтэй. Үүнийг нотолж, тус тусын засгийн газраас зохих ёсоор олгосон бүрэн эрх бүхий дор гарын үсэг зурагчид эл зорилгоор энэхүү протоколд гарын үсэг зурцаав.

Лондон хотноо нэг мянга есөн зуун ерэн долоон оны есдүгээр сарын хорин зургааны өдөр үйлдэв.

VI ХАВСРАЛТ

АГААРЫГ ХӨЛӨГ ОНГОЦНООС БОХИРДУУЛАХААС СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ЖУРАМ

I бүлэг

НИЙТЛЭГ ЗААЛТУУД

1 дүгээр журам

Хэрэглэх хүрээ

Энэхүү хавсралтын 3, 5, 6, 13, 15, 18 болон 19 дүгээр журамд өөрөөр зааснаас бусад бүх төрлийн хөлөг онгоцонд энэхүү хавсралтын заалтуудыг хэрэглэнэ.

2 дугаар журам

Тодорхойлолт

Энэхүү хавсралтын зорилгод:

(1) "Хөлөг онгоцны ерөнхий байгууламжийн ижил төстэй үе шат гэж;

(а) тодорхой хөлөг онгоцны ерөнхий байгууламжийн ажил эхлэх үе;

(б) ерөнхий байгууламжид шаардагдах эд материалын тооцологдсон жингийн 1 хувь, эсхүл наад зах нь 50 тонноос бүрдэж буй болон аль ч тохиолдолд түүнээс бага жинтэй хөлөг онгоцыг угсрах үе шатыг хэлнэ.

(2) "Түлшээр үл таслах" гэж хаягдал шатаах зуухны үйл ажиллагааны хэвийн нөхцөлд шатаах зуухны ажлын хэм 850-1200°C байхад шатаах зууханд хүний туслалцаагүйгээр хаягдал хийх үйл ажиллагааг хэлнэ.

(3) "Ялгаруулалт" гэж хөлөг онгоцноос агаар мандал болон далай уруу гадагшлах энэхүү хавсралтын дагуу хяналтанд байх бодисыг хэлнэ.

(4) Энэхүү хавсралтын 12 дугаар журамд заасан "Шинэ суурилуулалт" гэж өмнө нь суурилуулсан систем, тоног төхөөрөмж, дулаан тусгаарлагчдыг сэргээн засварлах буюу дахин цэнэглэх болон бусад материал, мөн гал сөнөөх зөврийн нэгжүүдийг дахин цэнэглэхээс бусад систем, тоног төхөөрөмж, түүний дотор гал сөнөөх зөврийн шинэ нэгжүүд, дулаан тусгаарлагч буюу бусад материалыг энэхүү хавсралт хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс хойш хөлөг онгоцонд суурилуулахыг хэлнэ.

(5) "Азотын хэт исэл (NOx)-ийн техникийн нөхцөл" гэж хөлөг онгоцны дизель хөдөлгүүрээс ялгаруулж буй азотын хэт исэл (NOx) –ийг хянах Бага хурлын 2 дугаар тогтоолоор баталж, Байгууллагаас нэмэлт өөрчлөлт оруулсан техникийн нөхцөлийг хэлэх бөгөөд тухайн нэмэлт өөрчлөлтийг энэхүү конвенцийн 16 дугаар зүйлийн заалтын дагуу Хавсралтын нэмэлт хавсралтад хэрэглэгдэх нэмэлт өөрчлөлт оруулах журмын дагуу баталж, хүчин төгөлдөр болгосон.

(6) "Озон задлагч бодисууд" гэж энэхүү хавсралтыг хэрэглэх буюу тайлбарлах үед хүчин төгөлдөр үйлчлэх "Озоны давхаргыг задлагч бодисууд" –ын талаархи Монреалын 1987 оны протоколын 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт тодорхойлж, тус протоколын А, В, С болон Е хавсралтуудад хяналт тавихаар жагсаасан бодисуудыг хэлнэ.

"Озон задлагч бодисууд" –ад хөлөг онгоцны тавцангаас олж тогтоож болох бөгөөд дор дурдсанаар үл хязгаарлагдах.

Галон 1211 Бромхлорфтортметан
Галон 1301 Бромгурванфтортметан
Галон 2402 1, 2 -Хөёрбромт- 1, 2, 2-дөрвөнфтортэтан (мөн Галон 114B2 гэж нэрлэдэг)
CFC-11 Гурванхлорфтортметан
CFC-12 Хоёрхлорфтортметан
CFC-113 1, 1, 2-Гурванхлорт-1, 2, 2-Гурванфтортэтан
CFC-114 1, 2-Хоёрхлорт-1, 1, 2, 2-Дөрвөнфтортэтан
CFC-115 Хлорпентафтортэтан

"Бохир тос" гэж түлш шатахуунаас хальж асгарсан бохир тос болон тос тусгаарлагчаас ялгарсан илүүдэл, гол болон туслах машинуудын тос тосолгооны хаягдал болон ус тусгаарлагчийн ёроол, тос шүүгч тоног төхөөрөмжүүд болон тосгууруудаас гарсан ашиглагдсан тос, хаягдлыг хэлнэ.

"Хөлөг онгоцны тавцан дээрх шатаах ажиллагаа" гэж, хэрэв хаягдал болон бусад зүйлс нь хөлөг онгоцны хэвийн үйл ажиллагааны туршид үүсч бий болсон бол тухайн хөлөг онгоцны тавцан дээрх хаягдал болон бусад зүйлсийг шатааж устгах ажиллагааг хэлнэ.

"Хөлөг онгоцон дээрх хаягдал шатаах зуух" гэж шатаах зориулалтаар зохион бүтээгдсэн хөлөг онгоцон дээрх тоног төхөөрөмжийг хэлнэ.

"Усгардсан хөлөг онгоцууд" гэж тэдгээрийн ёроолын дам нурууг нь зангидсан буюу угсралтын түүнтэй төстэй үе шатанд байгаа хөлөг онгоцыг хэлнэ.

"Хүхрийн исэл (SOx)-ийн ялгаруулалтыг хянах бүс нутаг" гэж хөлөг онгоцноос ялгаруулж буй (SOx)-ээс үүдсэн агаарын бохирдолт болон түүнээс үүдэж эх газар, далайн орчинд үзүүлэх сөрөг нөлөөнөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих, түүнийг багасгах талаар шаардлагатай арга хэмжээ авах тусгай эрх олгосон бүс нутгийг хэлнэ. (SOx)-ийн ялгаруулалтыг хянах бүс нутаг нь энэхүү хавсралтын 14 дүгээр журамд тусгасан жагсаалтыг хамаарна.

"Шингэн тээвэрлэгч хөлөг онгоц" гэж энэхүү конвенцийн I хавсралтын 1(4) дэх журамд тодорхойлсон газрын тос тээвэрлэгч, эсхүл II хавсралтын 1(1) дэх журамд тодорхойлсон химийн бодис тээвэрлэгч хөлөг онгоцыг хэлнэ.

"1997 оны протокол" гэж 1978 оны протоколоор нэмэлт өөрчлөлт оруулсан Далайг хөлөг онгоцноос бохирдуулахаас сэргийлэх тухай олон улсын 1973 оны конвенцид нэмэлт өөрчлөлт оруулсан 1997 оны протоколыг хэлнэ.

3 дугаар журам Ерөнхий хязгаарлалт

Энэхүү хавсралтын журмуудыг дараахь тохиолдолд хэрэглэхгүй:

(а) далай дахь амьдралыг хамгаалах буюу хөлөг онгоцны аюулгүй ажиллагааг хангах зайлшгүй шаардлагаар үүссэн аливаа ялгаруулалтын үед; эсхүл

(б) хөлөг онгоц болон түүний тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтлээс үүссэн аливаа ялгаруулалтын үед;

(i) ялгаруулалтыг багасгах, эсхүл урьдчилан сэргийлэх зорилгоор ялгаруулалтыг илрүүлсэн, эсхүл эвдрэл гэмтэл үүссэний дараа урьдчилан сэргийлэх боломжит бүх арга хэмжээг авч хэрэгжүүлэх; болон

(ii) хэрэв хөлөг онгоцны эзэмшигч буюу ахмадын болгоомжгүйгээс, эсхүл эвдрэл гэмтлийг санаатайгаар үйлдсэн болон тэрхүү эвдрэл гэмтэл болзошгүй үр дүнд хүргэхийг мэдэж байснаас бусад үед.

4 дүгээр журам Адил тэгш чанар

(1) Захиргаа нь энэхүү хавсралтаар шаардаж буйтай ижил төстэй аливаа тоног төхөөрөмж, материал, эд анги болон аппаратыг хөлөг онгоцонд суурилуулахыг зөвшөөрч болох бөгөөд тэрхүү тоног төхөөрөмж, материал, хэрэгсэл болон аппарат нь наад захын үр ашигтай байх энэхүү хавсралтын шаардлагыг хангасан байна.

(2) Энэхүү хавсралтаар шаардаж буйтай ижил төстэй аливаа тоног төхөөрөмж, материал, эд анги болон аппаратыг хөлөг онгоцонд суурилуулахыг зөвшөөрч байгаа Захиргаа нь тэдгээрийн тухай мэдээлэл болон хэрэв байгаа бол зохих үйл ажиллагааныхаа талаар энэхүү конвенцийн бусад талд мэдэгдэхээр Байгууллагад хүргүүлнэ.

II бүлэг

Үзлэг хийх, гэрчилгээ олгох, хяналт тавих аргууд

5 дугаар журам Үзлэг, шалгалт хийх

(1) 400 тонн, түүнээс дээш тоннын бохир даацтай бүх хөлөг онгоц болон далайн ероонд суурилуулсан болон хөвж буй өрөмдлөгийн чамхагууд, мөн бусад төрлийн суурилуулгасан, эсхүл хөвөгч тавцангуудыг дараахь үзлэгт хамруулна:

(а) хөлөг онгоц ажил үйлчилгээнд хөвж эхлэхээс өмнө буюу энэхүү хавсралтын 6 дугаар журмын дагуу шаардаж буй гэрчилгээг эхний удаа олгохын тулд анхан шатны үзлэгийг хийнэ. Тухайн үзлэг нь хөлөг онгоцны тоног төхөөрөмж, систем, эд анги, механизм болон материал нь

энэхүү хавсралтын зохих шаардлагыг бүрэн хангаж байгааг тогтооход оршино;

(б) тогтмол давтамжтай үзлэгийг Захиргаанаас тодорхойлсон тодорхой хугацаанд, гэхдээ 5 жилээс хэтрүүлэхгүйгээр хийх бөгөөд энэхүү үзлэгээр хөлөг онгоцны тоног төхөөрөмж, систем, эд анги, механизм болон материал нь энэхүү хавсралтын зохих шаардлагыг бүрэн хангаж байгааг тогтооход оршино;

(с) гэрчилгээний хүчинтэй хугацаанд доод тал нь нэг удаа завсрын үзлэг хийх бөгөөд уг үзлэг нь хөлөг онгоцны тоног төхөөрөмж, систем, эд анги, механизм болон материал нь энэхүү хавсралтын зохих шаардлагыг бүрэн хангаж байгаа эсэх, ажлын зохих түвшинд байгаа эсэхийг тогтооход оршино. Нэг удаагийн гэрчилгээний хүчинтэй хугацаанд завсрын үзлэгийг зөвхөн нэг удаа хийж, гэрчилгээний хугацаа 2.5 жилээс хэтэрсэн тохиолдолд түүнийг гэрчилгээний хүчинтэй байх хугацааны тал хувийн өмнө буюу хойно нь 6 сарын дотор багтаан гүйцэтгэнэ. Завсрын үзлэг хийсэн тухай тэмдэглэлийг энэхүү хавсралтын 6 дугаар журмын дагуу олгосон гэрчилгээнд тусгана.

(2) Бохир даац нь 400 тонноос бага хөлөг онгоцуудын тухайд Захиргаа энэхүү хавсралтын зохих заалтуудад нийцүүлэх, түүнийг биелүүлэх талаар шаардлагатай арга хэмжээ авч болно.

(3) Энэхүү хавсралтын заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан хөлөг онгоцуудад хийх үзлэгийг Захиргааны ажилтнууд гүйцэтгэнэ. Захиргаа үзлэгийг эл зорилгоор томилогдсон байцаагчдад эл үзлэгээр хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагуудад даалгаж, гүйцэтгүүлж болно. Ийм байгууллагууд нь байгууллагаас батласан зааварчилгааг баримтлан ажиллана. Захиргаа нь үзлэгтэй холбогдуулан түүний үр дүнтэй болон гүйцэд хийгдсэний бүрэн баталгааг аль ч тохиолдолд гаргана.

(4) Энэхүү хавсралтын 13 дугаар журамд нийцүүлэх зорилгоор хөдөлгүүр болон тоног төхөөрөмжийн үзлэгийг Азотын хэт исэл (NOx)-ийн техникийн нөхцөлийн дагуу хийнэ.

(5) Захиргаа нь гэрчилгээний хүчинтэй байх хугацааны туршид хуваарьт бус шалгалтыг хийх хугацааг тогтооно. Эдгээр үзлэг нь тухайн тоног төхөөрөмж нь зориулалт, үйлчилгээндээ бүрэн тохирох явдлыг хангана. Эдгээр үзлэгийг Захиргааны хяналтын алба, хяналтын томилогдсон байцаагчид, хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагууд, эсхүл түүний хүсэлтээр бусад тал хэрэгжүүлж болно. Захиргаа энэхүү журмын (1) дэх хэсэгт заасны дагуу жил бүр үзлэг хийх эрх олгосон

бол дээр дурдсан хуваарьт бус шалгалтыг заавал хийхгүй. (2)

(6) Хяналтын томилогдсон байцаагч, эсхүл хүлээн зөвшөөрөгдсөн байгууллага тоног төхөөрөмжийн нөхцөл байдал нь гэрчилгээнд заасан үзүүлэлтийг үндсэндээ хангахгүй байгааг тогтоовол засч залруулах арга хэмжээг тэдгээр авахуулж Захиргаанд зохих ёсоор мэдэгдэнэ. Хэрэв засч залруулах арга хэмжээ аваагүй бол Захиргаа гэрчилгээг хураана. Хэрэв хөлөг онгоц өөр талын боомтод байрлаа бол боомтын улсын эрх бүхий зохих этгээдэд мөн нэн даруй мэдэгдэнэ. Захиргааны ажилтан, хяналтын томилогдсон байцаагч буюу хүлээн зөвшөөрөгдсөн байгууллага нь боомтын улсын бүрэн эрх бүхий зохих этгээдэд мэдэгдсэн бол холбогдох боомтын улсын засгийн газар тухайн ажилтан, хяналтын байцаагч буюу байгууллагад энэхүү журмын дагуу хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд нь шаардлагатай аливаа түлэмжийг үзүүлнэ. Энэхүү хавсралтын заалтуудад нийцүүлэн тоног төхөөрөмжийн бүрэн байдлыг нь хангах бөгөөд Захиргаанаас шууд зөвшөөрөхгүйгээр үзлэгт хамрагдсан тоног төхөөрөмж, систем, эд анги, механизм болон материалд өөрчлөлт хийж болохгүй. Эдгээр тоног төхөөрөмж, эд ангийг энэхүү хавсралтын заалтуудад нийцсэн тоног төхөөрөмж, эд ангиар шууд сольж болно. (3)

(7) Энэхүү хавсралтад заасан тоног төхөөрөмжийн үр ашиг болон бүрэн бүтэн байдалд бодитойгоор сөрөг нөлөө үзүүлэхүйц осол хөлөг онгоцонд тохиолдсон, эсхүл эвдрэл гарсан бол тухай бүр хөлөг онгоцны эзэмшигч буюу ахмад Захиргаа болон холбогдох гэрчилгээ олгох үүрэгтэй томилогдсон хяналтын байцаагч буюу хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагад боломжийн дагуу аль болох эрт мэдэгдэнэ. (3)

(8) Энэхүү хавсралтад заасан тоног төхөөрөмжийн үр ашиг болон бүрэн бүтэн байдалд бодитойгоор сөрөг нөлөө үзүүлэхүйц осол хөлөг онгоцонд тохиолдсон, эсхүл эвдрэл гарсан бол тухай бүр хөлөг онгоцны эзэмшигч буюу ахмад Захиргаа болон холбогдох гэрчилгээ олгох үүрэгтэй томилогдсон хяналтын байцаагч буюу хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагад боломжийн дагуу аль болох эрт мэдэгдэнэ. (3)

(9) Энэхүү хавсралтад заасан тоног төхөөрөмжийн үр ашиг болон бүрэн бүтэн байдалд бодитойгоор сөрөг нөлөө үзүүлэхүйц осол хөлөг онгоцонд тохиолдсон, эсхүл эвдрэл гарсан бол тухай бүр хөлөг онгоцны эзэмшигч буюу ахмад Захиргаа болон холбогдох гэрчилгээ олгох үүрэгтэй томилогдсон хяналтын байцаагч буюу хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагад боломжийн дагуу аль болох эрт мэдэгдэнэ. (3)

(10) Энэхүү хавсралтад заасан тоног төхөөрөмжийн үр ашиг болон бүрэн бүтэн байдалд бодитойгоор сөрөг нөлөө үзүүлэхүйц осол хөлөг онгоцонд тохиолдсон, эсхүл эвдрэл гарсан бол тухай бүр хөлөг онгоцны эзэмшигч буюу ахмад Захиргаа болон холбогдох гэрчилгээ олгох үүрэгтэй томилогдсон хяналтын байцаагч буюу хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагад боломжийн дагуу аль болох эрт мэдэгдэнэ. (3)

(11) Энэхүү хавсралтад заасан тоног төхөөрөмжийн үр ашиг болон бүрэн бүтэн байдалд бодитойгоор сөрөг нөлөө үзүүлэхүйц осол хөлөг онгоцонд тохиолдсон, эсхүл эвдрэл гарсан бол тухай бүр хөлөг онгоцны эзэмшигч буюу ахмад Захиргаа болон холбогдох гэрчилгээ олгох үүрэгтэй томилогдсон хяналтын байцаагч буюу хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагад боломжийн дагуу аль болох эрт мэдэгдэнэ. (3)

(12) Энэхүү хавсралтад заасан тоног төхөөрөмжийн үр ашиг болон бүрэн бүтэн байдалд бодитойгоор сөрөг нөлөө үзүүлэхүйц осол хөлөг онгоцонд тохиолдсон, эсхүл эвдрэл гарсан бол тухай бүр хөлөг онгоцны эзэмшигч буюу ахмад Захиргаа болон холбогдох гэрчилгээ олгох үүрэгтэй томилогдсон хяналтын байцаагч буюу хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагад боломжийн дагуу аль болох эрт мэдэгдэнэ. (3)

6 дугаар журам

Агаар бохирдуулахаас урьдчилан сэргийлэх олон улсын гэрчилгээ олгох

(1) Агаар бохирдуулахаас урьдчилан сэргийлэх олон улсын гэрчилгээг энэхүү хавсралтын 5 дугаар журмын заалтуудын дагуу үзлэг хийсэн дараахь хөлөг онгоцонд олгоно:

(а) нөгөө талын хэргийн харьяалалд орших боомт, эсхүл эргийн тоноглодсон зогсоолууд аялж буй 400 тонн буюу түүнээс дээш бохир даацтай аливаа хөлөг онгоц; болон

(б) 1997 оны протоколд оролцогч нөгөө талын бүрэн эрхт байдал, эсхүл хэргийн харьяалалд хамаарах ус уруу аялж буй хөвөгч тавцан болон өрөмдлөгийн цамхагууд

1997 оны протокол хүчин төгөлдөр болох өдрөөс өмнө зохион бүтээгдсэн хөлөг онгоцонд Агаар бохирдуулахаас урьдчилан сэргийлэх олон улсын гэрчилгээг энэхүү журмын (1) дэх хэсэгт нийцүүлэн, гэхдээ хөлөг онгоцыг хуурай зогсоолд зогсоох анхны хуваариас хойшмдуулахгүйгээр 1997 оны протокол хүчин төгөлдөр болсноос хойш 3 жилийн дотор олгоно.

(3) Энэхүү гэрчилгээг Захиргаа, эсхүл түүнээс бүрэн эрх олгосон аливаа этгээд буюу байгууллагын аль нэг нь олгоно. Аль ч тохиолдолд Захиргаа нь олгосон гэрчилгээний төлөө бүрэн хариуцлага хүлээнэ.

7 дугаар журам

Бусад улсын засгийн газраас гэрчилгээ олгох

(1) 1997 оны протоколд оролцогч талуудын засгийн газар нь Захиргааны хүсэлтээр хөлөг онгоцонд үзлэг хийж болох бөгөөд уг хөлөг онгоц энэхүү хавсралтын заалтуудын шаардлагыг хангаж байвал Агаар бохирдуулахаас урьдчилан сэргийлэх олон улсын гэрчилгээг хөлөг онгоцонд олгох буюу олгох бүрэн эрхийг энэхүү хавсралтын дагуу олгоно.

(2) Гэрчилгээний хуулбар болон үзлэг хийсэн тухай тайлангийн хуулбарыг хүсэлт гаргасан Захиргаанд аль болох түргэн хугацаанд хүргүүлнэ.

(3) Олгосон гэрчилгээ нь Захиргааны хүсэлтийн дагуу гарсан үр дүнгийн талаархи албан ёсны мэдээг агуулах бөгөөд энэхүү хавсралтын 6 дугаар журмын дагуу олгосон гэрчилгээний нэгэн адил хүлээн зөвшөөрөгдөж хүчин төгөлдөр болно.

(4) 1997 оны протоколд оролцогч тал бус улсын далбааг мандуулан хөвж буй хөлөг онгоцонд Агаар бохирдуулахаас урьдчилан сэргийлэх олон улсын гэрчилгээг олгохгүй.

8 дугаар журам

Гэрчилгээний загвар

Агаар бохирдуулахаас урьдчилан сэргийлэх олон улсын гэрчилгээ нь энэхүү хавсралтын 1 нэмэлт хавсралтад тусгасан загварын хэлбэрт нийцэж, олгосон улсын албан ёсны хэлээр үйлдэгдэнэ. Хэрэв хэрэглэж буй уг хэл нь англи, франц, испаниас өөр бол эх бичвэрийг эдгээр хэлний аль нэг рүү орчуулж хавсаргана.

9 дүгээр журам

Гэрчилгээний үйлчлэх болон хүчинтэй байх хугацаа

(1) Агаар бохирдуулахаас урьдчилан сэргийлэх олон улсын гэрчилгээг Захиргаанаас тогтоосон хугацаагаар олгох бөгөөд олгосон өдрөөс хойш 5 жилээс хэтрэхгүй байна.

- (2) Агаар бохирдуулахаас урьдчилан сэргийлэх олон улсын гэрчилгээний хүчинтэй байх 5 жилийн хугацааг (3) дахь хэсэгт зөвшөөрснөөс бусад тохиолдолд сунгахгүй.
- (3) Хэрэв Агаар бохирдуулахаас урьдчилан сэргийлэх олон улсын гэрчилгээний хүчинтэй байх хугацаа дуусах үед хөлөг онгоц үзлэгт орох, эсхүл далбааг нь мандуулах эрх олгосон улсын далайн боомтод байгаагүй бол Захиргаа нь гэрчилгээний хугацааг 5 сараас илүүгүй хугацаагаар сунгаж болно. Энэхүү сунгалт нь зөвхөн хөлөг онгоц далбааг нь мандуулах эрх олгосон улс уруу буцах аялалаа дуусгах, эсхүл үзлэгт хамрагдах болон зохистой шаардлагыг хангуулах зорилгоор хийгдэнэ. Далбааг нь мандуулах эрх олгосон улс, эсхүл үзлэгт орох газарт хүрэлцэн ирсний дараа хөлөг онгоц нь Агаар бохирдуулахаас урьдчилан сэргийлэх олон улсын гэрчилгээг шинээр авалгүйгээр тухайн сунгалтаар уг боомт, эсхүл улсыг орхин явах эрхгүй.
- (4) Агаар бохирдуулахаас урьдчилан сэргийлэх олон улсын гэрчилгээг дараахь аливаа нөхцөл байдал үүссэн тохиолдолд хүчингүй болгоно.

(а) энэхүү хавсралтын 5 дугаар журамд тодорхойлсон хугацаанд багтаж үзлэг болон шалгалтад хамрагдаагүй бол;

(б) энэхүү хавсралтын шаардлагад нийцсэн тоног төхөөрөмж, эд ангийг мөн тийм тоног төхөөрөмж, эд ангиар шүүд солихоос бусад тохиолдолд Захиргааны зөвшөөрөлгүйгээр энэхүү хавсралтад заасан тоног төхөөрөмж, систем, эд анги, механизм, эсхүл материалд чухал шаардлагатай ч засвар өөрчлөлт хийсэн бол. 13 дугаар журмын зорилгод чухал шаардлагатай засвар өөрчлөлтөд систем, эд анги, төхөөрөмж, эсхүл дизель хөдөлгүүрийн механизмыг сольж өөрчлөх, тохируулах ажил багтах бөгөөд үүний үр дүнд тухайн хөдөлгүүрийн азотын хэт ислийн зөвшөөрөгдөх хэмжээний түвшинг удаан хугацаанд хангаж чадахааргүй бол; эсхүл

(с) өөр улсын далбааг мандуулахаар хөлөг онгоцыг шилжүүлэхээс өмнөхөн, Шинэ гэрчилгээ олгож буй засгийн газраас энэхүү хавсралтын 5 дугаар журамд заасан нөхцөл шаардлагуудыг тухайн хөлөг онгоц бүрэн хангаж буй гэж үзсэн тохиолдолд л зөвхөн шинээр гэрчилгээ олгоно. Талуудын хооронд шилжүүлэх тохиолдолд тодорхой нэгэн газар шилжүүлсний дараа хэрэв 3 сарын дотор хүсэлт гаргасан бол тухайн хөлөг онгоц далбааг нь мандуулан хөвж байсан талын засгийн газраас нөгөө талын захиргаанд Агаар бохирдуулахаас урьдчилан сэргийлэх олон улсын гэрчилгээний хуулбарыг хөлөг онгоцыг шилжүүлэхээс өмнө аль болох түргэн

хугацаанд, боломжтой бол холбогдох үзлэг хийсэн тухай тайлангийн хуулбарын хамт хүргүүлнэ.

10 дугаар журам

Үйл ажиллагааны нөхцөл шаардлагад боомтын улсаас тавих хяналт

- (1) 1997 оны протоколд оролцогч нөгөө талын хэргийн харьяалал дахь далайн боомт буюу эргийн тоноглогдсон зогсоолд хөлөг онгоц хүрэлцэн ирэх үед энэхүү хавсралттай холбогдуулан үйл ажиллагааны холбогдох шаардлагуудыг тогтоох үүрэг бүхий тухайн талаас бүрэн эрх олгосон ажилтнууд агаарыг хөлөг онгоцноос бохирдуулахаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой хөлөг онгоцны үндсэн журмуудыг ахмад болон багийн гишүүд мэдэж байгаа эсэхэд эргэлзэх тодорхой үндэслэл байвал шалгалт хийнэ.
- (2) Энэхүү журмын (1) дэх хэсэгт заасан нөхцөл байдал үүсэх бол тухайн тал энэхүү хавсралтын шаардлагад нийцүүлэн зөвшөөрөл авах хүртэл хөлөг онгоцыг далайд гаргахгүй байх арга хэмжээг авна.
- (3) Энэхүү конвенцийн 5 дугаар зүйлд тодорхойлсон боомтын улсын хяналттай холбоотой үйл ажиллагааг энэхүү журмын дагуу хэрэгжүүлнэ.
- (4) Энэхүү журмын аль ч заалт энэхүү конвенцид тусгайлан заасан үйл ажиллагааны шаардлагуудад тавих хяналтыг хэрэгжүүлэх талын эрх үүргийг хязгаарласан гэж үзэхгүй.

11 дугаар журам

Зөрчил илрүүлэх, шийдвэр гүйцэтгэл

- (1) Энэхүү хавсралтын талууд гарсан зөрчлийг илрүүлэх, энэхүү хавсралтын заалтуудыг мөрдөх талаар зөрчил илрүүлэх, байгаль орчны хяналт шөжилгээ хийх, тайлан илтгэл бэлтгэх, нотлох баримтуудыг цуглуулах бүхий л бололцоотой болон практик арга хэмжээ авахад хамтран ажиллана.
- (2) Энэхүү хавсралт үйлчлэх хөлөг онгоцыг аль нэг талын боомт, эсхүл эргийн тоноглогдсон зогсоолд тухайн талаас томилсон буюу эрх олгосон ажилтнууд энэхүү хавсралтын заалтуудыг зөрчиж байгаа, энэхүү хавсралтад заасан аливаа бодисыг тухайн хөлөг онгоц ялгаруулж байгаа эсэхийг тогтоох зорилгоор шалгалт хийнэ. Хэрэв шалгалт нь энэхүү хавсралтыг зөрчиж байгааг тогтоовол зохих арга хэмжээг авахуулахаар тайлан илтгэлийг Захиргаанд хүргүүлнэ.
- (3) Энэхүү хавсралтын заалтуудыг зөрчиж, энэхүү хавсралтад заасан бодисуудын аль нэгийг тухайн хөлөг онгоц ялгаруулж

байгааг илрүүлсэн аль ч тал нотлох баримтыг Захиргаанд хүргүүлнэ. Хэрэв үүнийг практикт хэрэгжүүлж болохоор бол тухайн талаас эрх олгосон этгээд зөрчил гаргасан гэж сэжиглэж байгаа талаар хөлөг онгоцны ахмадад мэдэгдэнэ.

(4) Тухайн мэдээллийг хүлээж авсан Захиргаа нь уг нотлох баримтыг хүлээн авахын өмнө хэрэг явдлыг мөрдөн байцаах бөгөөд зөрчлийн талаархи илүү сайн болон цаашдын нотлох баримт ирүүлэх талаар бусад талд хүсэлт гаргаж болно. Хэрэв илэрсэн зөрчлийн хувьд зохих байцаан шийтгэх ажиллагаа явуулахад хангалттай баримт шаардлагатай байгаа бол Захиргаа нь тухайн байцаан шийтгэх ажиллагааг өөрийн хуульд нийцүүлэх арга хэмжээг аль болох түргэн хугацаанд авна. Захиргаа нь илрүүлсэн зөрчлийн талаар илтгэл хүргүүлсэн тал болон Байгууллагад авсан арга хэмжээгээ шуурхай мэдээлнэ.

(5) Хавсралтад заасан аливаа бодисыг энэхүү хавсралтыг зөрчиж дурын газар ялгаруулж байгаа хөлөг онгоцыг мөрдөн шалгах хүсэлтийг түүнийг нотлох хангалттай баримтын хамт аль нэг талаас хүлээж авсан тал энэхүү хавсралт үйлчлэх хөлөг онгоцыг түүний хэргийн харьяалалд хамаарах боомт, эсхүл эргийн тоноглогдсон зогсоолд хүрэлцэн ирэх үед нь шалгалт хийж болно. Тухайн мөрдөн байцаалтын талаархи тайланг энэхүү конвенцийн дагуу холбогдох арга хэмжээг авахуулахаар хүсэлт гаргасан тал болон Захиргаанд хүргүүлнэ.

(6) Энэхүү хавсралтыг хэрэглэх буюу тайлбарлах үед хөлөг онгоцуудаас далайн хүрээлэн буй орчинд учруулах бохирдлоос урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, хяналт тавихтай холбоотой хүчин төгөлдөр үйлчилж буй олон улсын эрх зүй, түүний дотор шийдвэр гүйцэтгэл, хамгаалахтай холбоотой хуулийг энэхүү хавсралтад тусгасан журам, стандартуудад нийцүүлэн *mutatis mutandis* хэрэглэнэ.

III бүлэг

Хөлөг онгоцуудаас ялгаруулж буй бохирдолд хяналт тавих шаардлага

12 дугаар журам

Озон задлагч бодисууд

(1) 3 дугаар журамд заасан нөхцөлийн дагуу озон задлагч аливаа бодисыг санаатайгаар ялгаруулахыг хориглоно. Санаатайгаар ялгаруулах гэдэгт систем, эсхүл тоног төхөөрөмжийг засварлах, үйлчилгээ тохируулга хийх, зөөж байрлуулах үед гарах хийн ялгаруулалтыг хамааруулах бөгөөд озон задлагч бодисыг дахин

боловсруулах, эргэн ашиглахтай холбоотойгоор алдагдсан бага зэргийн алдагдлыг хамааруулахгүй. Озон задлагч бодисын санаатай эсэхээс үл хамааран алдагдлаас үүсч буй ялгаруулалтыг 1997 оны протоколд оролцогч талууд зохицуулж болно.

(2) Гагцхүү гидрохлорфторкарбон агуулсан (HCFCs) тоног төхөөрөмжийг 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл шинээр суурилуулахыг зөвшөөрөхөөс бусад тохиолдолд озон задлагч бодис агуулсан тоног төхөөрөмжийг шинээр суурилуулахыг бүх хөлөг онгоцонд хориглоно.

(3) Энэхүү журамд дурдсан бодисууд болон ийм бодис агуулсан тоног төхөөрөмжийг хөлөг онгоцуудаас зөөж шилжүүлэх үедээ хамгаалалтын зохих төхөөрөмж хэрэглээр хүргүүлнэ.

13 дугаар журам

Азотын исэл (NOx)

(1) (a) Энэхүү журмыг дараахь тохиолдолд хэрэглэнэ:

(i) 2000 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр, эсхүл түүнээс хойш угсрагдсан хөлөг онгоцон дээр суурилуулагдсан тус бүрдээ 130 квт-аас илүү гаралтын хүчдэл бүхий дизель хөдөлгүүр бүрт;

(ii) 2000 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр, эсхүл түүнээс хойш үндсэн эргэлтдээ орсон 130 квт-аас илүү гаралтын хүчдэл бүхий дизель хөдөлгүүр бүрт.

(b) Энэхүү журам дараахь тохиолдолд үйлчлэхгүй:

(i) аюул ослын зориулалттай дизель хөдөлгүүрүүд аврах завин дээр суурилагдсан болон зөвхөн аюул ослын үед ашиглахаар зориулагдсан тоног төхөөрөмжийн хөдөлгүүрүүдэд болон

(ii) далбааг нь мандуулах эрхийг хөлөг онгоцонд олгосон улсын бүрэн эрхт байдал буюу эргийн харьяалалд байх усанд аялж буй хөлөг онгоцуудад суурилуулсан хөдөлгүүрүүд болон тухайн хөдөлгүүрүүд нь Захиргаанаас тогтоосон (NOx)-ийн хяналтын арга хэмжээний аль нэг хувилбарт хамаарагдаж байвал.

(c) Энэ хэсгийн (a) дэд хэсгийн аль ч заалт тухайн хөлөг онгоц далбааг нь мандуулах эрх олгосон улсын эргийн тоноглогдсон зогсоол буюу боомтын хооронд аялж байгаа бол энэхүү протокол хүчин төгөлдөр болох өдрөөс өмнө угсрагдсан хөлөг онгоцон дээр суурилуулагдсан аливаа дизель хөдөлгүүрүүд буюу хөдөлгүүрийн үндсэн эргэлтийн туршилтад орсон хөлөг онгоцонд энэхүү журмын заалтыг хэрэглэх явдлыг Захиргаанаас чөлөөлсөн мэтээр үзэхгүй.

(2) (a) Энэхүү журмын зорилгод "үндсэн эргэлт" гэдэг нь хөдөлгүүрт хийх дараахь тохируулгыг ойлгоно.

(i) хөдөлгүүрийг 2000 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр, эсхүл түүнээс хойш зохион бүтээгдсэн шинэ хөдөлгүүрээр сольсон;

(ii) хөдөлгүүрт (NOx)-ийн техникийн нөхцөлөөр тодорхойлсон аливаа бодит өөрчлөлтийг хийсэн; буюу

(iii) хөдөлгүүрийн тахир голын эргэлтийн үргэлжлэх хамгийн дээд хэмжээ 10 гаруй хувиар өссөн бол.

(b) энэ хэсгийн (a) дэд хэсэгт заасан өөрчлөлтийн үр дүнд үүссэн (NOx)-ийн ялгаруулалтыг (NOx)-ийн техникийн нөхцөлд нийцүүлэн Захиргаагаар батлуулахаар баримтжуулна.

(3) Энэхүү хавсралтын 3 дугаар журамд заасан нөхцөлийн дагуу дизель хөдөлгүүр бүрийн ажиллагааг энэхүү журмын нэмэлтээр хориглосноос бусад тохиолдолд хөдөлгүүрээс гарах азотын хэт ислийн (NOx)-хэмжээг (NO₂ нийт ялгаруулалтын жингээр тооцоологдох) дор дурдсанаар хязгаарлана:

(i) n - нь 130 гртм –аас бага байх үед

17.0 гртм/Квт.ц

(ii) n – нь 130 буюу түүнээс их, гэхдээ 2000 гртм –аас бага байвал $45.0 \cdot n^{-0.2}$ гртм/Квт.ц

(iii) n – нь 2000 гртм буюу түүнээс их бол 9.8 гртм/Квт.ц

n = хөдөлгүүрийн голын эргэлтийн хурдны тогтоогдсон хэмжээ (минут тутамд өөрчлөгдсөн тахир голын өөрчлөлтүүд)

Газрын тосноос цэвэршүүлэн гаргаж авсан гидрокарбонь хольц бүхий түлшийг хэрэглэх үед туршилтын горим заавар болон хэмжих аргууд нь (NOx) –ийн техникийн нөхцөлд нийцсэн байх бөгөөд энэхүү хавсралтын II нэмэлт хавсралтад заасан Туршилтын үе давтамж болон Нөлөөлөх хүчин зүйлүүдийг байнга анхаарна.

(b) Энэ хэсгийн (a) дэд хэсгийн заалтыг үл харгалзан дараахь тохиолдолд дизель хөдөлгүүрийн ажиллагааг зөвшөөрнө:

(i) Азотын исэл-(NOx)-ийн техникийн нөхцөлд нийцүүлэн Захиргаанаас батласан утааны тортог цэвэрлэх системийг хөлөг онгоцон дээрх (NOx)-ийн ялгаруулалтыг (a) дэд хэсэгт тодорхойлсон хязгаараас хэтрүүлэхгүй байлгах, багасгах зорилгоор хөдөлгүүрт суурилуулах; эсхүл

(ii) Байгууллагаас боловсруулж батласан холбогдох зааварчилгааг харгалзан Захиргаанаас хүлээн зөвшөөрсөн хэсгийн хөлөг онгоцон дээрх азотын исэл (NOx)-ийн ялгаруулалтыг (a) дэд хэсэгт тодорхойлсон хязгаараас хэтрүүлэхгүй, багасгахаар суурилуулсан адил төстэй бусад аливаа аргаар.

14 дугаар журам

Хүхрийн исэл (SOx)

Ерөнхий шаардлагууд

(1) Хөлөг онгоцонд ашиглаж буй мазутын аливаа тосон дахь хүхрийн агуулга 4, 5 % -ийн м/м-ээс хэтрэхгүй байна.

(2) Хөлөг онгоцонд ашиглаж зорилгоор ханган нийлүүлж буй мазутын тосны үлдэгдэл дэх хүхрийн дэлхий даяар мөрдөх дундаж агуулгад Байгууллагаас боловсруулж мөрдүүлсэн зааварчилгааг харгалзан хяналт шинжилгээ хийнэ.

Хүхрийн исэл (SOx)- ийн ялгаруулалтад нь хяналт тавих бүс нутгийн хүрээнд тавигдах шаардлагууд:

(3) Энэхүү журмын зорилгод Хүхрийн исэл (SOx)-ийн ялгаруулалтад нь хяналт тавих бүс нутгуудад:

(a) I нэмэлт хавсралтын 10(1)(b) журамд тодорхойлсон Балтийн тэнгисийн бүс нутаг;

(b) Энэхүү хавсралтын III нэмэлт хавсралтад тусгасан агаарыг хөлөг онгоцоноос бохирдуулахаас сэргийлэх талаархи заалтын хувьд Хүхрийн исэл (SOx)- ийн ялгаруулалтад нь хяналт тавих бүс нутгууд гэж тодорхойлсон журам болон шалгуур үзүүлэлтүүдэд нийцүүлэн боомтын бүс нутгийг оролцуулан Байгууллагаас тогтоосон далай тэнгисийн бусад бүс нутаг.

(4) Хүхрийн исэл (SOx)- ийн ялгаруулалтад нь хяналт тавих бүс нутаг дахь хөлөг онгоц дараахь нөхцөлүүдээс ядаж л аль нэгийг хангаасан байна:

(a) Хүхрийн исэл (SOx)- ийн ялгаруулалтад нь хяналт тавих бүс нутгуудад үйл ажиллагаа явуулж буй хөлөг онгоцонд ашиглаж буй мазутын тосон дахь хүхрийн агуулгыг 1.5 % м/м –ээс хэтрүүлэхгүй байх;

(b) Байгууллагаас боловсруулсан зааварчилгааг харгалзан Захиргаанаас батласан утааны тортог цэвэрлэх системийг хөлөг онгоц, түүний дотор үндсэн болон туслах хөдөлгүүрээс ялгаруулж буй хүхрийн ислийн нийт хэмжээг багасгах зорилгоор хэрэглэх бөгөөд ялгаруулалтад дахь хүхрийн давхар ислийн нийт жинг тооцоолсноос бага буюу 6.0 гртм (SOx)/Квт.ц байлгана. Хэрэв боомтын улсын эрх бүхий этгээдээс Байгууллагад танилцуулж батлуулсан шалгуур үзүүлэлтүүдэд үндэслэн тухайн хаягдал нь хаалттай боомт, зогсоол, далайн булан тохойн экосистемд сөрөг нөлөө үзүүлэхгүй хөлөг онгоцоноос сайтар баримтжуулснаас бусад үед эдгээр тоног төхөөрөмжийн ашиглалтаас гарч буй хаягдлыг далайн булан тохой, хаалттай боомт, зогсоолд буулгаж, хаяхыг хориглоно. Байгууллага нь эдгээр шалгуур үзүүлэлтийг Конвенцид оролцогч бүх талд хүргүүлнэ; эсхүл

(c) (b) дэд хэсэгт тодорхойлсонтой адил түвшинд (SOx)-ийн ялгаруулалтыг хязгаарлах зорилгоор тогтоож мөрдүүлэх технологийн бусад аливаа арга. Эдгээр аргыг Байгууллагаас боловсруулсан зааварчилгааг харгалзан Захиргаанаас батална.

(5) Энэхүү журмын (4)(а) хэсэг болон (1) хэсэгт дурдсан мазутын тосон дахь хүхрийн агуулгыг энэхүү хавсралтын 18 дугаар журмаар мазутын тос ханган нийлүүлэгчдэд тавьж буй шаардлагаар баримтжуулна.

(6) Энэхүү журмын (4)(а) хэсэгт нийцүүлэн мазутын тусгай тос ашиглаж буй эдгээр хөлөг онгоц Хүхрийн исэл (SOx)-ийн ялгаруулалтад хүхрийн агуулга нь 1.5 % m^3 тн –ээс хэтэрч буй бүх түлш тосыг хяналт тавих бүс нутагт нэвтрэхээс өмнө мазутын тосны үйлчилгээний системээс тохирох цаг хугацаанд бүрэн цэвэрлэнэ. Мазутын тос агуулах бортого сав нэг бүрт байгаа хүхрийн агуулга нь бага (хүхрийн агуулга нь 1.5%-тэй тэнцүү буюу түүнээс бага) түлшний эзэлхүүн, түүнчлэн түлш солих аливаа үйл ажиллагаа явуулах үе дэх хөлөг онгоцны байрлал, цаг хугацаа, он, сар, өдрийг Захиргаанаас батласан хөлөг онгоцны дэвтэрт тэмдэглэнэ.

(7) Энэхүү журмын (3)(b) хэсгийн дагуу Хүхрийн исэл (SOx)-ийн ялгаруулалтад хяналт тавих бүс нутгуудийг тусгайлан тодорхойлж буй энэхүү протоколд оруулсан нэмэлт өөрчлөлт болон энэхүү протокол хүчин төгөлдөр болсноос хойш эхний арван хоёр сарын хугацаанд энэхүү журмын (3)(а) хэсэгт дурдсан, эсхүл энэхүү журмын (3)(b) хэсгийн дагуу Хүхрийн исэл (SOx)-ийн ялгаруулалтад хяналт тавих бүс нутгуудад нэвтэрч буй хөлөг онгоцуудыг энэхүү журмын (6) болон (4) хэсгийн шаардлагууд, мөн энэхүү журмын (5) хэсгийн шаардлагаас чөлөөлөх бөгөөд харин тэдэнд энэхүү журмын (4)(а) хэсэг хамаарна.

15 дугаар журам

Ууршилттай органик нэгдлүүд (VOCs)

(1) 1997 оны протоколд оролцогч талуудын хэргийн харьяалалд хамаарах боомтууд буюу эргийн тоноглогдсон зогсоолуудад шингэн тээвэрлэгч хөлөг онгоцуудаас ууршилттай органик нэгдлүүд (VOCs)-ийн ялгаруулалтыг зохицуулахдаа энэ журмын заалтуудад нийцүүлнэ.

(2) 1997 оны протоколд оролцогч аливаа талын ууршилттай органик нэгдлүүд (VOCs)-ийн ялгаруулалтыг зохицуулахаар тодорхойлсон, түүний хэргийн харьяалалд хамаарах боомтууд буюу эргийн тоноглогдсон зогсоолуудын талаар Байгууллагад мэдэгдэнэ. Энэхүү мэдэгдэлд хяналтад хамаарах шингэн тээвэрлэгч хөлөг онгоцны хэмжээ, ачаа тээвэрлэхэд шаардагдах уур ялгаруулалтыг хянах системүүд болон тэрхүү хяналт үйлчилж эхлэх өдрийн

талаархи мэдээллийг агуулна. Мэдэгдлийг үйлчилж эхлэхээс өмнө наад зах нь 6 сарын өмнө танилцуулсан байна.

Шингэн тээвэрлэгч хөлөг онгоцноос ялгаруулж буй ууршилттай органик нэгдлүүд (VOCs)-ийг нь зохицуулахаар 1997 оны протоколд оролцогч аль нэг талын засгийн газраас тодорхойлсон боомтууд буюу эргийн тоноглогдсон зогсоолууд нь Байгууллагаас боловсруулсан аюулгүй ажиллагааны хэм хэмжээг харгалзах бөгөөд тухайн засгийн газар, тогтоосон боомтууд буюу эргийн тоноглогдсон зогсоолуудыг уур ялгаруулалтыг хянах системээр хангаж, хөлөг онгоцыг үндэслэлгүйгээр саатуулахаас зайлсхийх хэлбэрээр аюулгүй ажиллагааг баримтлан үйл ажиллагаагаа явуулна.

Байгууллага 1997 оны протоколд оролцогч талуудаас тогтоосон боомтууд болон эргийн тоноглогдсон зогсоолуудын жагсаалтыг 1997 оны протоколд оролцогч бусад тал болон Байгууллагын гишүүн улс орнуудад мэдээллийн зорилгоор хүргүүлнэ.

(5) Энэ журмын (2) дахь хэсгийн заалтын дагуу уурын ялгаруулалтад тавих хяналтад хамаарах шингэн тээвэрлэгч бүх хөлөг онгоцыг Байгууллагаас боловсруулсан аюулгүй ажиллагааны хэм хэмжээг харгалзан Захиргаанаас батласан уур хуримтлуулах системээр хангах бөгөөд энэхүү системийг тухайн ачааг ачаалах хугацааны туршид ашиглана. Энэхүү журамд нийцүүлэн уур ялгаруулалтын хяналтын системийг суурилуулсан тоноглогдсон зогсоолуудад уур хуримтлуулах системийг суурилуулаагүй шингэн тээвэрлэгч хөлөг онгоцуудыг (2) дахь хэсэгт тодорхойлсон өдрөөс хойш 3 жилийн хугацаанд зогсоож болно.

(6) Энэхүү журам нь метан агуулаагүй ууршилттай органик нэгдлүүдийг хөлөг онгоцон дээр бүрэн бүтэн хадгалах буюу тэдгээрийг эрэг дээр бүрэн бүтэн буцаах боломж олгож буй ачаалалтын төрөл болон тогтоогч системтэй үед зөвхөн хий тээвэрлэгчдэд хамаарна.

16 дугаар журам

Хөлөг онгоцон дээр хаягдал шатаах

(1) (5) хэсэгт зааснаас бусад тохиолдолд хөлөг онгоцон дээр хаягдал шатаах ажиллагааг зөвхөн хөлөг онгоцон дээрх хаягдал шатаах зууханд гүйцэтгэнэ.

(2) (а) энэ хэсгийн (b) дэд хэсэгт зааснаас бусад тохиолдолд 2000 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр буюу түүнээс хойш хөлөг онгоцонд суурилуулсан хаягдал шатаах зуух бүр энэхүү хавсралтын IV нэмэлт

- хавсралтад тусгасан шаардлагыг хангана. Хаягдал шатаах зуух нэг бүрийг Байгууллагаас боловсруулсан хөлөг онгоцон дээрх хаягдал шатаах зууханд зориулагдсан тусгай нөхцөлүүд, хэм хэмжээг харгалзан Захиргаанаас батална.
- (b) Захиргаа нь 1997 оны протокол хүчин төгөлдөр болох өдрөөс өмнө хөлөг онгоцон дээр суурилуулсан хаягдал шатаах аливаа зуухыг тухайн хөлөг онгоцууд далбааг нь мандуулах эрх олгосон улсын бүрэн эрхт байдал болон хэргийн харьяалалд хамаарах усанд аялж буй бол энэхүү хэсгийн (a) дэд хэсэгт зааснаас чөлөөлж болно.
- (3) 1996 оны протоколоор өөрчлөлт оруулсан Далайг хог хаягдал болон бусад бодисоор бохирдуулахаас урьдчилан сэргийлэх тухай 1972 оны олон улсын конвенцоор тавьсан хориг, эсхүл бусад шаардлагад энэхүү журмын аль ч заалт харшлахгүй.
- (4) Дараахь бодис, хаягдлыг хөлөг онгоцон дээр шатаахыг хориглоно:
- (a) энэхүү конвенцийн I, II болон III хавсралтуудад заасан тээвэрлэсэн ачааны үлдэгдэл болон тэдгээрийн сав баглаа боодлын бохир материалууд;
- (b) полихлорт бифенилүүд (PCBs);
- (c) энэхүү конвенцийн V хавсралтад тодорхойлсон хэмжээнээс илүү агуулгатай хүнд металлтай хаягдлууд; болон
- (d) галогенийн нэгдлүүдийг агуулсан цэвэршүүлсэн газрын тосны бүтээгдэхүүнүүд.
- (5) Хөлөг онгоцны хэвийн үйл ажиллагааны явцад ялгарсан үйлдвэрийн бохир ус, тундас шавар болон бохир тосыг хөлөг онгоцон дээр үндсэн болон туслах хөдөлгүүр, эсхүл уурын тогооны ойролцоо газар шатааж болох бөгөөд харин боомт, тоноглогдсон зогсоолуудын нутаг дэвсгэрт болон далайн эргийн булан тохой, голын эхэнд шатаахыг хориглоно.
- (6) Хөлөг онгоцон дээр Далайн олон улсын байгууллагаас батласан загварын гэрчилгээ авсан хаягдал шатаах зуухнаас бусад зууханд поливинил хлорид (PVCs)-ыг шатаахыг хориглоно.
- (7) Энэхүү журмын нөхцөлийн дагуу хаягдал шатаах зуухтай бүх хөлөг онгоц энэхүү хавсралтын IV нэмэлт хавсралтын 2 дахь хэсэгт тодорхойлсон хязгаарын дотор хаягдал шатаах зуухыг хэрхэн ажилуулахыг тусгайлан зааж үйлдвэрлэгчээс боловсруулсан гарын авлагатай байна.
- (8) Хаягдал шатаах аливаа зуухны үйл ажиллагааг хариуцах үүрэг хүлээсэн ажилтнуудыг үйлдвэрлэгчээс боловсруулсан гарын авлагаар зааж сурган чадвартай болгосон байна.

- (9) Шаталтаас үүссэн утааны яндангийн гарал дахь агаарын хэмд байнгын хяналт тавих шаардлагатай бөгөөд зөвшөөрөгдсөн хамгийн доод хэм болох 850°C –ээс доош болох үед хөлөг онгоцон дээрх тасралтгүй тэжээгдэх ёстой хаягдал шатаах зууханд орох хаягдлыг тасалдуулахаас сэргийлнэ. Багц хаягдал шатаах хөлөг онгоцны журмын нэгжийг ажиллуулж эхэлснээс хойш 5 минутын дараа шатаах тасалгааны доторх агаарын хэм 600°C хүрэхээр тодорхойлно.
- (10) Хөлөг онгоцон дээр энэхүү журмын шаардлагаас илүү буюу нийцэж байгаа халуун агаарын эрчимт урсгалээр хаягдал боловсруулах адил төстэй бүтэц загвартай тоноглол хэрэгслийг боловсруулах, суурилуулах болон ажиллуулахад энэхүү журмын аль ч заалт харшлахгүй.

17 дугаар журам

Тоног төхөөрөмжийг хүлээн авч бүртгэх

- (1) 1997 оны протоколд оролцогч талуудын засгийн газар бүр дараахь тохиолдолд зохих дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээнэ:
- (a) хөлөг онгоцон дээр байгаа сэн задлагч бодисууд болон ийм төрлийн бодис агуулсан тоног төхөөрөмжийг хөлөг онгоцуудаас шилжүүлэн зөөх үед хөлөг онгоцыг засвар үйлчилгээ хийх өөрийн боомтод хүлээж авах хэрэгцээ гарсан
- (b) хүлээн зөвшөөрөгдөж батлагдсан утаа шүүн цэвэрлэх системээс ялгаруулж буй шүүн цэвэрлэгдсэн утааны тортог хаягдлыг далайн хүрээлэн бүр орчинд хаяхыг энэхүү хавсралтын 14 дүгээр журмын заалтаар зөвшөөрөөгүй бол тухайн тортог хаягдлыг хаях хөлөг онгоцыг өөрийн боомт, тоноглогдсон зогсоолууд, эсхүл засвар үйлчилгээ хийх боомтод аливаа сааталгүйгээр хүлээж авах хэрэгцээ гарсан;
- (c) хөлөг онгоцны орон задлагч бодисуудын тоног төхөөрөмж эвдэрч хэмхэрсэн болон ийм бодис агуулсан төхөөрөмж, багаж хэрэгслийг хөлөг онгоцноос зөөвөрлөх үед түүнийг хүлээж авах хэрэгцээ гарсан бол.
- (2) 1997 оны протоколд оролцогч тал бүр энэхүү журамд заасан дэмжлэгийг үзүүлэх боломжгүй, эсхүл зохисгүй гэж үзэх бүх тохиолдлын талаар Байгууллагын гишүүдэд мэдэгдэхээр Байгууллагад хүргүүлнэ.

18 дугаар журам

Мазут тосны чанар

- (1) Шатаах, тослох зорилгоор хөлөг онгоцонд ачаалсан болон ашиглаж буй мазут тос нь энэхүү хавсралтад нийцсэн дараахь шаардлагыг хангасан байна.
- (a) (b) дэд хэсэгт зааснаас бусад
- (i) мазут тос нь нефтийг цэвэршүүлэх замаар гаргасан гидрoкарбoны холимог байна. Үүнд үзүүлэлтүүдийнх нь зарим талуудыг сайжруулах зорилгоор хийсэн

нэмэлтүүдийн бага зэргийн нэгдлийг үл хамааруулна;

(ii) мазут тос нь органик бус хүчил агуулаагүй байна;

(iii) мазут тос нь дараахь ямар нэгэн нэмэгдэл бодис буюу химийн хаягдал агуулаагүй байна;

(1) хөлөг онгоцны аюулгүй байдалд эрсдэл учруулахаар буюу машин механизмын үзүүлэлтүүдэд хортой нөлөөлөх; эсхүл

(2) ажиллагсад хортойгоор нөлөөлөх; эсхүл (6)

(3) агаарын бохирдлыг ихэсгэхэд бүхэлд нь нөлөөлж буй.

(b) нефтийг цэвэршүүлэхээс өөр аргаар гаргасан шатах, тослох зориулалттай мазут тос нь дараахь шаардлагыг хангасан байна:

(i) агуулж буй хүхэр нь энэхүү хавсралтын 14 дүгээр журамд зааснаас хэтрэхгүй;

(ii) хөдөлгүүрээс ялгаруулж буй азотын исэл нь энэхүү хавсралтын 13(3) дахь журамд заасан хязгаараас хэтрэхгүй;

(iii) органик бус хүчил агуулаагүй; болон

(iv) (1) хөлөг онгоцны аюулгүй (7) байдалд эрсдэл учруулахаар; буюу машин механизмын үзүүлэлтүүдэд хортойгоор нөлөөлөхгүй;

(2) ажиллагсад хортойгоор нөлөөлөхгүй; буюу

(3) агаарын бохирдлыг ихэсгэхэд бүхэлд нь нөлөөлөхгүй байна.

(2) Энэхүү журам нь нүүрс, түүний хатуу хэлбэрт нэгдлүүд, эсхүл цөмийн түлшинд хамаарахгүй

(3) Энэхүү хавсралтын 5, 6 дугаар журмын нөхцөлийн дагуу хөлөг онгоц бүрт шатаах, тослох зорилгоор ачаалсан болон ашиглаж буй мазут тосны шинж чанарыг бункерийн ачаа тээврийн дагалдах баримтад нарийвчлан бичих бөгөөд энэхүү хавсралтын V нэмэлт хавсралтад тодорхойлсон мэдээллээс дутахгүй мэдээллийг агуулна.

(4) Бункерын ачаа тээврийн дагалдах баримтыг зохих үед шалгалт хийхэд уншихад ялбар байлгахуйцаар хөлөг онгоцонд байрлуулна. Баримтыг мазутын тосыг ачаалснаас хойш 3 жилийн туршид хадгална.

(5) (a) 1997 оны протоколд оролцогч талуудын засгийн газрын эрх бүхий байгууллага түүний боомт, эсхүл эргийн тоноглогдсон зогсоолд хөлөг онгоцууд энэхүү хавсралтад дурдсаны дагуу хүрэлцэн ирэх үед дурын хөлөг онгоцны бункерын ачаа тээврийн дагалдах баримтыг шалгаж болох бөгөөд ачаа тээврийн дагалдах баримт бүрийг хувилах, хуулбар тус бүр нь тухайн ачаа тээврийн баримтын үнэн зөв хуулбар гэдгийг батлахыг хөлөг онгоцны ахмад буюу түүнийг хариуцаж буй этгээдээс

шаардаж болно. Түүнчлэн эрх бүхий байгууллага нь тухайн баримтыг олгосон боомттой зөвлөлдөх замаар баримт тус бүрийн агуулгыг магадлаж болно.

(b) Ачаа тээврийн дагалдах баримтын шалгалт болон энэ хэсгийн дагуу эрх бүхий байгууллагын гэрчилсэн хуулбаруудыг хөлөг онгоцыг үндэслэлгүйгээр саатуулахгүйн тулд боломжийн хэрээр шуурхай хийж гүйцэтгэнэ.

Бункерын ачаа тээврийн баримтад ачаалсан мазутын тосны дээжийг Байгууллагаас боловсруулах зааварчилгааг харгалзан дагалдуулна. Тухайн дээжинд ханган нийлүүлэгчийн төлөөлөгч болон ахмад, эсхүл бункерын үйл ажиллагааг ханган бүрдүүлэх ажиллагааг хариуцаж буй ажилтанг гарын үсэг зурж тамга дарах бөгөөд ачаалсан өдрөөс хойш аль ч тохиолдолд арван хоёр сараас багагүй хугацаанд мазутын тосыг үндсэнд нь зарцуулж дуусах хүртэл хөлөг онгоцны хяналтад байлгана.

1997 оны протоколд оролцогч талууд, тэдгээрийн томилсон зохих эрх бүхий байгууллагууд дараахь үүрэг хүлээнэ:

(a) мазутын тосны орон нутгийн ханган нийлүүлэгчдийн бүртгэлийг хөтлөх;

(b) энэхүү журмын шаардлагад нийцэж буй дээж болон бункерын ачаа тээврийн баримтад заасан нөхцөлийг хангуулахыг орон нутгийн ханган нийлүүлэгчдээс шаардах, тэдгээрийн нийлүүлж буй мазутын тос нь энэхүү хавсралтын 14 болон 18 дугаар журмын шаардлага хангасан тохиолдолд тос нийлүүлэгчдэд гэрчилгээ олгох;

(c) шаардлагатай тохиолдолд бункерын ачаа тээврийн баримтын хуулбарыг боомтын улс шалгалт хийж баталгаажуулах зорилгоор наад зах нь гурван жилээр хадгалахыг орон нутгийн ханган нийлүүлэгчдээс шаардах;

(d) бункерын ачаа тээврийн баримтад заасныг зөрчиж мазутын тос тээвэрлэсэн тос нийлүүлэгчдэд зохих арга хэмжээ авах; (e) энэхүү хавсралтын 14, эсхүл 18 дугаар журмуудын шаардлагад нийцүүлэлгүйгээр мазутын тос тээвэрлэж хүрэлцэн ирсэн аливаа хөлөг онгоцыг Захиргаанд нь мэдэгдэх; болон

(f) мазутын тос ханган нийлүүлэгчид энэхүү хавсралтын 14, эсхүл 18 дугаар журмаар тодорхойлсон шаардлагад нийцүүлээгүй бүх тохиолдолд 1997 оны протоколд оролцогч талуудад хүргүүлэхээр Байгууллагад мэдээлэх.

1997 оны протоколд оролцогч талуудаас боомтын улсад хэрэгжүүлж буй шалгалтын хувьд талууд дараахь үүрэг хүлээнэ:

(а) тухайн улсын хэргийн харьяаллынх нь дагуу ачаа тээврийн дагалдах баримтыг олгосон оролцогч тал буюу оролцогч тал биш улсуудад мазутын тосыг тээвэрлэхэд тавигддаг шаардлагуудыг зөрчсөн тухай, мөн холбогдох бүх мэдээллийг мэдээлж; болон (b) мазутын тос тээвэрлэхэд тавигдаж буй шаардлагад үл нийцэж байгааг илрүүлсэн бол түүнийг засч залруулах зохих арга хэмжээ авах явдлыг хангах.

19 дүгээр журам

Ховогч тавцангууд болон өрөмдлөгийн цамхагуудад тавих шаардлага

- (1) Суурилуулсан, эсхүл хөвж буй тавцангууд болон өрөмдлөгийн цамхагуудыг энэхүү журмын (2) болон (3) дахь хэсэгт заасан нөхцлүүдийг дагуу энэхүү хавсралтын шаардлагад нийцүүлнэ.
- (2) Энэхүү конвенцийн 2(3)(b)(ii) зүйлүүдэд заасны дагуу далайн ёроолын ашигт малтмалын нөөцөд хайгуул хийх, ашиглах болон түүнтэй холбоотой эрэг орчимд боловсруулалт хийсний улмаас шууд үүсч буй ялгаруулалтыг энэхүү хавсралтад заасан нөхцлүүдэд хамааруулахгүй. Энэ ялгаруулалтад дор дурдсаныг хамааруулна:

(а) далайн ёроолын ашигт малтмалын нөөцөд хайгуул хийх, ашиглах болон түүнтэй холбоотой эрэг орчимд боловсруулалт хийсний үр дүнд шууд болон шууд бусаар бий болсон, түүний дотор огт хүлээгдээгүй нөхцлүүдээс үүссэн шаталт болон сайтар гүйцэтгэсэн туршилын ажиллагааны туршид шингэн, эсхүл шавар булингар, гидрокарбоны холимогийн шаталтыг хязгаарлахгүйгээр цооног өрөмдөх үеийн шаталтаас бий болсон бодисууд үнс болтол шатснаас үүдсэн ялгаруулалт;

(b) усан дор өрөмдлөг хийх болон цооног ухах үед дээш хөөрөх ууршигтай хийн холимогийн ялгаруулалт;

(c) далайн ёроолын ашигт малтмалыг хадгалах, олборлох, боловсруулахтай шууд буюу түүнтэй хослон үүсэх ялгаруулалт;

(d) далайн ёроолын ашигт малтмалын нөөцөд хайгуул хийх, ашиглах болон түүнтэй холбоотой эрэг орчимд боловсруулалт хийхэд л зөвхөн зориулагдсан дизель хөдөлгүүрүүдийн ялгаруулалт.

(3) энэхүү хавсралтын 18 дугаар журмын шаардлага нь Захиргаанаас хүлээн зөвшөөрч батласан тос хэмээн сонгож үйлдвэрлэн цаашид ашиглаж байгаа гидрокарбоны ашиглалтад хамаарахгүй.

I нэмэлт хавсралт

АГААР БОХИРДУУЛАХААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ОЛОН УЛСЫН ГЭРЧИЛГЭЭНИЙ ЗАГВАР

(8 дугаар журам)

АГААР БОХИРДУУЛАХААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ОЛОН УЛСЫН ГЭРЧИЛГЭЭ

1978 оны протоколоор өөрчлөлт оруулсан Далайг хөлөг онгоцноос бохирдуулахаас сэргийлэх тухай 1973 оны олон улсын конвенцид (цаашид "Конвенц" гэх) нэмэлт өөрчлөлт оруулсан 1997 оны протоколын шаардлагад нийцүүлж Засгийн газраас бүрэн эрх олгосон дор дурдсан байгууллага олгов:

(Тухайн орны албан ёсны нэр)

Болон

(Конвенцийн нөхцлүүдийн дагуу эрх олгогдсон байгууллага буюу эрх бүхий этгээдийн албан ёсны нэр)

Хөлөг онгоцны нэр	Ялгах дугаар буюу үсэг	ДОУБ-аас олгосон дугаар	Бүртгэсэн боомт	Нийт бохир даац

Хөлөг онгоцны төрөл: шингэн тээвэрлэгч

Шингэн тээвэрлэгчээс бусад хөлөг онгоц

1. Энэхүү хөлөг онгоцыг Конвенцийн VI хавсралтын 5 дугаар журамд нийцүүлэн үзлэгт хамруулсныг ҮҮГЭЭР ГЭРЧИЛЖ БАЙНА.

2. Энэхүү үзлэгээр хөлөг онгоцны тоног төхөөрөмж, систем, эд анги, механизм болон материал нь Конвенцийн VI хавсралтын журмын шаардлагад бүрэн нийцэж байна.

Энэхүү гэрчилгээ нь Конвенцийн VI хавсралтын 5 дугаар журамд заасан үзлэгийн нөхцөлийн дагуу хүртэл хүчинтэй.

Олгосон:

(Гэрчилгээ олгосон газар)

(Олгосон огноо)

(зохих ёсоор эрх олгогдсон албан гушаатны гарын үсэг)

(бүрэн эрхт байгууллагын албан ёсны тамга буюу тэмдэг)



ЖИЛ БҮРИЙН БОЛОН ЗАВСРЫН ҮЗЛЭГИЙН БАТАЛГАА

Энэхүү хөлөг онгоц Конвенцийн холбогдох нөхцлүүдийг хангаж байгааг баталж Конвенцийн VI хавсралтын 5 дугаар журмын шаардлагын дагуу үзлэгт хамрагдсаныг ҮҮГЭЭР ГЭРЧИЛЖ БАЙНА.

Жил бүрийн үзлэг: Гарын үсэг зурсан (зохих ёсоор эрх олгогдсон албан тушаалтны гарын үсэг)
Газар
Огноо

(эрх бүхий байгууллагын зохих ёсны тамга буюу тэмдэг)

Жил бүрийн* /завсрын үзлэг*: Гарын үсэг зурсан (зохих ёсоор эрх олгогдсон албан тушаалтны гарын үсэг)
Газар
Огноо

(эрх бүхий байгууллагын албан ёсны тамга буюу тэмдэг)

Жил бүрийн* /завсрын үзлэг*: Гарын үсэг зурсан (зохих ёсоор эрх олгогдсон албан тушаалтны гарын үсэг)

Газар
Огноо
(эрх бүхий байгууллагын албан ёсны тамга буюу тэмдэг)
Жил бүрийн үзлэг: Гарын үсэг зурсан (зохих ёсоор эрх олгогдсон албан тушаалтны гарын үсэг)
Газар
Огноо

(эрх бүхий байгууллагын албан ёсны тамга буюу тэмдэг)

- аль тохирохын доогуур нь зурах

АГААР БОХИРДУУЛАХААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ОЛОН УЛСЫН ГЭРЧИЛГЭЭНД ОРУУЛАХ НЭМЭЛТ (IAPP ГЭРЧИЛГЭЭ)

ХӨЛӨГ ОНГОЦНЫ БАЙГУУЛАМЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ ТОДОРХОЙЛЖ БИЧИХ

1978 оны протоколоор өөрчлөлт оруулсан Далайг хөлөг онгоцноос бохирдуулахаас сэргийлэх тухай 1973 оны олон улсын конвенцийн (цаашид "Конвенц" гэх) VI хавсралтын заалтуудыг баримтлан

Тэмдэглэх нь:

1. Энэхүү бичлэг нь Агаар бохирдуулахаас урьдчилан сэргийлэх олон улсын гэрчилгээ (IAPP)- ний байнгын Хавсралт болно. IAPP гэрчилгээг хөлөг онгоцонд шалгалт хийхэд хялбар дөхөм байнга байлгана.

2. Хэрэв бичлэгийн эх хувь англи, франц, эсхүл испани хэлээр биш бол эдгээр хэлний аль нэгт хөрвүүлсэн орчуулгыг эх бичвэрт хавсаргана.

3. "тийм", "тохирох" гэсэн хариултад зориулсан дөрвөлжин нүдэнд (x) хэрээс болон "үгүй", "үл тохирох" гэсэн хариултад зориулсан дөрвөлжин нүдэнд (-) тэмдгийг тус тус тавина.

4. Энэхүү бичлэгт дурдсан дүрмүүдэд хэрэв өөрөөр заагаагүй бол Конвенцийн VI хавсралтын журмыг болон Далайн олон улсын байгууллагаас батласан бусад дүрэм, шийдвэрийг баримтална.

1. Хөлөг онгоцны онцлог шинж тэмдэгүүд

- 1.1 Хөлөг онгоцны нэр
- 1.2 Ялгаж /онцлох/ дугаар буюу үсгүүд
- 1.3 Далайн олон улсын байгууллагаас олгосон дугаар
- 1.4 Бүртгэгдсэн боомт
- 1.5 Нийт /бохир/ даац
- 1.6 Хөлөг онгоцны өөрийн дам нурууг зангидсан буюу угсралтын адил төстэй үе шатанд байсан огноо

1.7 (хэрэв боломжтой бол) үндсэн хөдөлгүүрийн эргэлтийг эхлүүлсэн огноо (13 дугаар журам)

2 Хөлөг онгоцноос ялгаруулж буй хорт бодисуудад тавих хяналт

2.1. Озон задлагч бодисууд (12 дугаар журам)

2.1.1 Дор дурдсан гал унтраах багц иж бүрдэл- /систем/-үүд болон тоног төхөөрөмж, даралтын дор битүүмжлэгдсэн /баллон/ сав суулганд хадгалсан хор хэрэгслийг үйлчилгээнд хэвээр үлдээх:

Багц иж бүрдэл- /систем/ тоног төхөөрөмж	Хөлөг онгоцон дээрх байршил
--	-----------------------------

2.1.2 Фторхлорт нүүрстөрөгч (CFC)-ийг агуулж буй дор дурдсан багц иж бүрдэл болон тоног төхөөрөмжийг үйлчилгээнд хэвээр үлдээх:

Багц иж бүрдэл- /систем/ тоног төхөөрөмж	Хөлөг онгоцон дээрх байршил
--	-----------------------------

2.1.3 Гидро-хлорофторткарбон (HCFC)-ыг агуулж буй 2020 оны 1 дүгээр сарын 1-ээс өмнө суурилуулсан дор дурдсан тоног төхөөрөмжийг үйлчилгээнд хэвээр үлдээх:

Багц иж бүрдэл- /систем/ тоног төхөөрөмж	Хөлөг онгоцон дээрх байршил
--	-----------------------------

2.2 Азотын исэл (NOx) (13 дугаар журам)

2.2.1 2000 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр гэхэд буюу түүнээс хойш зохион бүтээгдэж хөлөг онгоцонд суурилуулагдсан 130 квт –аас илүү гаралтын хүчдэлтэй дор дурдсан

дизель хөдөлгүүрүүдийн 13 дугаар журмын (3)(а)-д заасан ялгаруулалтын хэм хэмжээг азотын исэл (NOx)-ийн техникийн нөхцөлийн дагуу хянан шалгана:

Үйлдвэрлэгч болон загвар	Серийн дугаар	Ашиглагдсан жил	Гаралтын хүчдэл /квт/	Тооцоологдсон хурд (RPM)
--------------------------	---------------	-----------------	-----------------------	--------------------------

2.2.2 2000 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр гэхэд буюу түүнээс хойш 13 (2) журмын дагуу үндсэн эргэлтийн туршилтад орсон 130 квт-аас илүү гаралтын хүчдэлтэй дор дурдсан дизель хөдөлгүүрүүдийн 13 дугаар журмын (3)(а)-д заасан ялгаруулалтын хэм хэмжээг азотын исэл (NOx)-ийн техникийн нөхцөлийн дагуу хянан шалгана:

Үйлдвэрлэгч болон загвар	Серийн дугаар	Ашиглагдсан жил	Гаралтын хүчдэл /квт/	Тооцоологдсон Хурд (RPM)
--------------------------	---------------	-----------------	-----------------------	--------------------------

2.2.3 2000 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр гэхэд буюу түүнээс хойш зохион бүтээгдэж, хөлөг онгоцонд суурилуулагдсан 130 квт-аас илүү гаралтын хүчдэлтэй болон 2000 оны 1 дүгээр сарын 1-н гэхэд буюу түүнээс хойш 13 (2) журмын дагуу үндсэн эргэлтийн туршилтад орсон 130 квт-аас илүү гаралтын хүчдэлтэй дор дурдсан дизель хөдөлгүүрүүдийг яндангийн утаа цэвэрлэх иж бүрдэл- /систем/-ээр эсхүл адил тэнцүү бусад аргаар 13 (3) журамд болон азотын исэл (NOx)-ийн техникийн нөхцөлд нийцүүлэн тоноглоно:

Үйлдвэрлэгч болон загвар	Серийн дугаар	Ашиглагдсан жил	Гаралтын хүчдэл /квт/	Тооцоологдсон Хурд (RPM)
--------------------------	---------------	-----------------	-----------------------	--------------------------

2.2.4 2.2.1, 2.2.2-т ба дээр дурдсан 2.2.3-т заасны дагуу дор дурдсан дизель хөдөлгүүрүүдийг азотын давхар исэл (NOx)-ийн техникийн нөхцөлд нийцүүлэн азотын исэл (NOx)-ийн ялгаруулалтын хяналт шинжилгээ болон бичлэг хийх тоног төхөөрөмж, хэрэгслээр тоноглоно:

Үйлдвэрлэгч болон загвар	Серийн дугаар	Ашиглагдсан жил	Гаралтын хүчдэл /квт/	Тооцоологдсон Хурд (RPM)
--------------------------	---------------	-----------------	-----------------------	--------------------------

2.3 Хүхрийн исэл (SOx) (14 дүгээр журам)

2.4 Ууршилттай органик нэгдлүүд (VOCs) (15 дугаар журам)

2.3.1 14(3) дугаар журмаар тодорхойлсон Хүхрийн исэл (SOx) –ийн ялгаруулалтад хяналт тавих бүс нутгийн хил хязгаарын дотор хөлөг онгоц үйл ажиллагаа явуулах үедээ тухайн хөлөг онгоц дараахь шаардлагыг хангана:

2.4.1 Шингэн тээвэрлэгч хөлөг онгоцуудад Далайд аюулгүй байдлыг хангах хорооны 585 дугаар удирдамжид нийцүүлэн хүлээн зөвшөөрч батласан ууршилтыг буцаан цуглуулах тоног төхөөрөмжийг суурилуулсан байна.

1 агуулах /бункер/-ийн ачааны /тээврийн/ дагалдах баримтад баталгаажуулсан нийт тосны хүхрийн агуулга 1.5% м/м-иас хэтрэхгүй байх; буюу

2.5 Хаягдал шатаах зуухтай хөлөг онгоцууд:

2 яндангийн утаа цэвэрлэх хүлээн зөвшөөрч батлагдсан тоног төхөөрөмж нь хүхрийн ислийн (SOx) ялгаруулалтыг 6.0 г SOx/квт.ц –аас доош багасгах; буюу

1 Далайн байгаль орчныг хамгаалах хорооны нэмэлт өөрчлөлт оруулсан 76(40) тогтоолд нийцүүлэн тоноглогдсон байх.

3 хүлээн зөвшөөрч батлагдсан бусад технологи хэрэглэсэн бол хүхрийн ислийн (SOx) ялгаруулалтыг 6.0 г SOx/квт.ц –аас доош багасгана.

2 Далайн байгаль орчныг хамгаалах хорооны нэмэлт өөрчлөлт оруулсан 76 (40) тогтоолд нийцүүлэн тоноглогдоогүй 2000 оны 1 дүгээр сарын 1-ээс өмнө суурилуулсан байх.

Энэхүү бичлэг нь бүх талаараа үнэн зөв гэдгийг ҮҮГЭЭР ГЭРЧИЛЖ БАЙНА.

Үйлдсэн:

(Бичлэг хийсэн газар)

(Олгоосон огноо)

(Бичлэг үйлдсэн эрх олгогдсон этгээдийн гарын үсэг)

(Эрх бүхий байгууллагын албан ёсны тамга буюу тэмдэг)

II нэмэлт хавсралт

Хөдөлгүүрийн тахир голын эргэлтэд хийх туршилтууд түүнд нөлөөлөх хүчин зүйлс

(13 дугаар журам)

Азотын исэл (NOx)-ийн Техникийн нөхцөлд тусгайлан заасан тооцоолох арга болон туршилтын ёс горимыг ашиглан энэхүү хавсралтын 13 дугаар журамд нийцүүлэн азотын исэл (NOx)-ийн хязгаарлалтыг далайн хөлөг онгоцны дизель хөдөлгүүрүүдэд мөрдөж буйг хянан баталгаажуулахын тулд тэдгээрийн тахир голын эргэлтэд дараахь туршилтууд

болон түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг хэрэглэнэ:

.1 үндсэн хөдөлгүүр, түүний дотор цахилгаан удирдлагатай дизель хөдөлгүүртэй хөлөг онгоцуудад зориулсан далайн зориулалттай тогтмол эргэлттэй хөдөлгүүрүүдэд эргэлтийн E2 туршилтыг хэрэглэнэ.

.2 хувьсах давтамжтай сэнс, сэлүүрт эргэлтийн E2 туршилтыг хэрэглэнэ.

.3 үндсэн хөдөлгүүрийн ажлын гол сэнс болон туслах хөдөлгүүрийн ажлын сэнс, сэлүүрт эргэлтийн E3 туршилтыг хэрэглэнэ.

.4 тогтмол эргэлттэй туслах хөдөлгүүрүүдэд эргэлтийн D2 туршилтыг хэрэглэнэ.

.5 дээр дурдсанд хамрагдаагүй хувьсах давтамжтай эргэлттэй, хувьсах ачаалалтай туслах хөдөлгүүрүүдэд эргэлтийн C1 туршилтыг хэрэглэнэ.

"Тогтмол эргэлттэй үндсэн хөдөлгүүр"-ийн эргэлтийн туршилт хийх (түүний дотор цахилгаан удирдлагатай дизель буюу хувьсах давтамжтай сэнс, сэлүүр суурилуулсан)

Эргэлтийн туршилтын E2 төрөл	Эргэлт	100%	100%	100%	100%
	Хүчдэл	100%	75%	50%	25%
	Нөлөөлөх хүчин зүйлс	0.2	0.5	0.15	0.15

"Үндсэн хөдөлгүүрийн ажлын гол сэнс болон туслах хөдөлгүүрийн ажлын сэнс"-энд эргэлтийн туршилт хийх

Эргэлтийн туршилтын E3 төрөл	Эргэлт	100%	91%	80%	63%
	Хүчдэл	100%	75%	50%	25%
	Нөлөөлөх хүчин зүйлс	0.2	0.5	0.15	0.15

"Тогтмол эргэлттэй туслах хөдөлгүүрт" эргэлтийн т... хийх

Эргэлтийн туршилтын D2 төрөл	Эргэлт	100%	100%	100%	100%	100%
	Хүчдэл	100%	75%	50%	25%	10%
	Нөлөөлөх хүчин зүйлс	0.5	0.25	0.3	0.3	0.1

"Хувьсах давтамжтай эргэлттэй болон хувьсах ачаалалтай туслах хөдөлгүүрүүдэд" эргэлтийн туршилт хийх

Эргэлтийн туршилтын C1 төрөл	Эргэлт	Хэвийн хэм хэмжээ				Завсрын			Зогссон
	Эргэх үе	100%	75%	50%	10%	100%	75%	50%	0%
	Нөлөөлөх хүчин зүйлс	0.15	0.15	0.15	0.1	0.1	0.1	0.1	0.15

III нэмэлт хавсралт

нутгийг батлуулахаар Байгууллагад хэлэлцүүлнэ.

Хүхрийн исэл (SOx) –ийн ялгаруулалтад хяналт тавих бүс нутгийг тодорхойлох журам, шалгуур үзүүлэлтүүд (14 дүгээр журам)

1. Зорилго

1.1 Энэхүү хавсралтын зорилго нь хүхрийн исэл (SOx) –ийн ялгаруулалтад хяналт тавих бүс нутгийг тодорхойлох журам, шалгуур үзүүлэлтүүдийг тогтооход оршино. Хүхрийн исэл (SOx) –ийн ялгаруулалтад хяналт тавих бүс нутгийг тодорхойлох зорилго нь хөлөг онгоцуудын үйлчилгээгээр газар болон далайн орчинд үзүүлж буй хортой нөлөө болон тэднээс ялгаруулж буй хүхрийн исэл (SOx) –ээр агаарыг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх, бохирдлыг багасгах, хяналт тавихад оршино.

1.2 Хөлөг онгоцуудаас ялгаруулж буй хүхрийн исэл (SOx) агаар бохирдуулахаас урьдчилан сэргийлэх, бохирдлыг багасгах болон түүнд хяналт тавих хэрэгцээ, баталгаагаар дэмжигдвэл хүхрийн исэл (SOx) –ийн ялгаруулалтад хяналт тавих бүс

2. Хүхрийн исэл (SO_x) –ийн ялгаруулалтад хяналт тавих бүс нутгийг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүдийн санал

2.1 Хүхрийн исэл (SOx) –ийн ялгаруулалтад хяналт тавих бүс нутгийг тодорхойлох саналыг зөвхөн 1997 оны протоколын хэлэлцэн тохирогч улсууд л гаргана. Хэлэлцэн тохирогч хоёр буюу түүнээс олон улс тухайн бүс нутгийн хувьд нийтлэг ашиг сонирхолтой бол тэд харилцан тохиролцсон санал боловсруулж ирүүлнэ.

2.2 Энэхүү санал нь:

1. Хөлөг онгоцуудаас ялгаруулж буй хүхрийн исэл (SOx) –д хяналт тавихаар санал болгож буй бүс нутгийн хил хязгаарыг тухайн бүс нутгийг тэмдэглэсэн газрын зургийг иш үндэс болгож нарийвчлан дүрслэх;

2. Хөлөг онгоцуудаас ялгаруулж буй хүхрийн исэл (SOx) –ийн нөлөөгөөр газар нутаг болон далайн орчинд учирч буй эрсдлийг тодруулан бичих;

3. Хөлөг онгоцуудаас ялгаруулж буй хүхрийн исэл (SOx) –д хяналт тавихаар санал болгож буй бүс

нутагт үйл ажиллагаа явуулж буй хөлөг онгоцуудаас ялгаруулж буй хүхрийн исэл (SOx)-д үнэлгээ хийх нь хэлэлцүүлж буй газар болон далайн орчинд тэдгээрийн үзүүлж буй хортой нөлөө болон хүхрийн исэл (SOx)-ээр, түүний дотор хүхрийн ислийн нэгдлээр агаар бохирдуулахаас сэргийлэхэд нэмэр болно. Энэхүү үнэлгээ нь хүхрийн исэл (SOx)-ийн ялгаруулалт хуурай газрын болон усны экосистем, байгалийн нөхөн үржихүйн нутаг дэвсгэр, амьдрах орчин, усны чанар, хүмүүсийн эрүүл мэнд болон шаардлагатай бол соёл, шинжлэх ухааны ач холбогдолтой бүс нутгуудад хэрхэн нөлөөлж буй тодорхойлолтыг агуулна. Холбогдох огноо түүний дотор ашигласан арга зүй, эх сурвалжийг тогтоосон байна.

4. Хөлөг онгоцуудаас ялгаруулж буй хүхрийн исэл (SOx) –д хяналт тавихаар санал болгож буй бүс нутгийн цаг уурын нөхцөл байдалд хамаарах шаардлагатай мэдээлэл болон газар, далайн орчинд учрах эрсдэл, ялангуяа давамгайлж буй салхины чиглэл, байр зүй, геолог зүй, далай судлал, морфологи болон исэлдлийн түвшин буюу агаар бохирдуулах өндөр идэвхжлийн магадлал ихэсгэх бусад нөхцлийг удирдлага болгоно.

5. Хөлөг онгоцуудаас ялгаруулж буй хүхрийн исэл (SOx) –д хяналт тавихаар санал болгож буй бүс нутаг дахь хөлөг онгоцуудын навигацын шинж чанар болон түүний нягтрал, загвар.

6. Хэлэлцэн тохирогч улсуудаас хэрэгжүүлэхээр санал болгосон хяналтын арга хэмжээ буюу хэлэлцэн тохирогч улсуудад хандсан хүхрийн исэл (SOx) ялгаруулалтаас тухайн бүс нутагт үзүүлж буй газарт суурилсан эх үүсвэртэй эрсдэл нь бодитой оршин байгаа болон үйл ажиллагааны өрсөлдөөнийг арга хэмжээнүүдийн хэлэлцүүлгийн хамт энэхүү конвенцийн VI хавсралтын 14 дүгээр журмын заалтад нийцүүлэн хүлээн зөвшөөрнө.

2.3 Хүхрийн исэл (SOx) –ийн хяналтын бүс нутгийн газар зүйн хил хязгаар нь дээр дурдсан холбогдох шалгуур үзүүлэлтүүд, түүний дотор санал болгож буй бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй хөлөг онгоцуудаас ялгаруулж буй хүхрийн исэл

(SOx), түүний нэгдэл, навигацын нягтрал болон салхины чиглэл, нөхцлүүдэд үндэслэгдэнэ.

2.4 Тухайн бүс нутгийг хүхрийн исэл (SOx) –ийн хяналтын бүс нутаг хэмээн тодорхойлох саналыг Байгууллагаас тогтоосон дүрэм, журмуудад нийцүүлэн боловсруулж Байгууллагад танилцуулна.

3. *Хүхрийн ислийн ялгаруулалтад нь хяналт тавих бүс нутгийг Байгууллага батлах, үнэлгээ хийх журмууд*

3.1 Байгууллага хэлэлцэн тохиролцогч улс буюу улсуудаас боловсруулж түүнд танилцуулсан санал нэг бүрийг авч хэлэлцэнэ.

3.2 Хүхрийн исэл (SOx) –ийн хяналтын бүс нутгийг энэхүү хавсралтад нэмэлт оруулах замаар хэлэлцэж, энэхүү конвенцийн 16 дугаар зүйлд нийцүүлэн хүлээн зөвшөөрч хүчин төгөлдөр болгоно.

3.3. Байгууллага тухайн саналд үнэлгээ хийхдээ дээр дурдсан 2 дахь хэсгийн өмнө заасан хүлээн зөвшөөрч батлуулахаар ирүүлсэн санал бүрт агуулагдсан шалгуур үзүүлэлтүүд болон газарт үндэслэгдсэн хяналттай харьцуулахад хөлөг онгоцуудаас ялгаруулж буй хүхрийн нэгдлүүдийг багасгахтай холбогдон гарах өртөг зардлыг анхааралтай авч үзнэ.

4. *Хүхрийн исэл (SOx) –ийн Хяналтын бүс нутагт үйл ажиллагаа явуулах*

4.1 Энэхүү бүс нутагт хөлөг онгоцууд нь далайн аливаа ажиллагаа явуулж буй Талууд бүс нутагт явуулж буй үйл ажиллагаатайгаа холбогдох аливаа мэдээллийг Байгууллагад мэдэгдэх явдлыг хөхиүлэн дэмжинэ.

IV нэмэлт хавсралт

Хөлөг онгоцон дээрх хаягдал шатаах зуухны ашиглалтыг батлах, хязгаар тогтоох хэлбэр

(16 дугаар журам)

(1) 16 дугаар журмын (2)-т тодорхойлсон хөлөг онгоцон дээрх хаягдал шатаах зуухууд нь тус



бүрдээ Далайн олон улсын байгууллагаас батласан загварын гэрчилгээтэй байна. Энэхүү гэрчилгээнд нийцсэн хаягдал шатаах зуухууд нь 16 дугаар журмын (2)-т тодорхойлсон хэм хэмжээг мөрдлөг болгож зохион бүтээгдсэн буюу суурилагдсан байна. Зуухны загвар нэг бүрийг үйлдвэрлэсэн үйлдвэрт нь тусгайлсан төрөл тус бүрээр үйл ажиллагааны батлагдсан туршилтад оруулах буюу Захиргааны хяналтын дор тоног төхөөрөмжийн батлагдсан туршилтад энэхүү хавсралтын (2)-дэд хэсэгт тодорхойлсон хязгаарын дотор хаягдал шатаах зуухны галч нар тодорхойлохоор батлагдсан туршилтын төрөл ангилалд зориулан тодорхойлсон тос/хаягдлын дараахь хэм хэмжээг баримтлан оруулна:

Ашигласан тосны найрлага:

ашигласан тосны 75% нь HFO-оос;

түрхэж тослох тосны хаягдал 5%;
тос солонгорсон ус 20%.

Хатуу биет хаягдлын найрлага:

хоол хүнсний хаягдлын 50%
50% нь хаягдлаас
ойролцоогоор 30% нь цаас,
——— " ——— 40% нь картон
——— " ——— 10% нь даавуу эд зүйлсийн тасархай
——— " ——— 20% нь хуванцар,
нийлэг

Холимог хаягдал 50 хүртэл хувийн чийглэг, галд тэсвэртэй хатуу биетийн хольц нь 7% - хүртэл байна.

(2) 16(2)-журамд тодорхойлогдсон хаягдал шатаах зуухууд дараахь хязгаарын дотор ажиллана:

шатаах зуухны тасалгаан доторх O_2 – н хэмжээ: 6-12%

яндангийн утааны нүүрс төрөгчийн CO –н дээд хэмжээ: 200 мг /MJ

яндангийн хөөний дээд хэмжээ:
BACHARACH 3 буюу RINGELMAN 1
(харлалт 20%)

(хөө, тортогны хэмжээ ихэссэнийг, эхэлснээс нь хойш зөвхөн маш богино хугацаанд л зөвшөөрнө).

Үнсэнд үлдсэн үл шатагч жижиг хэсгүүд:
жингийн 10% хүртэл

Шатаах зуухны тасалгааны утааны яндангийн гаралт дахь халууны хэмжээ:
850-1200°С байна.

V нэмэлт хавсралт

Бункерын ачаа тээврийн дагалдах баримтад тусгагдвал зохих мэдээллүүд

(18(3) журам)

Хүрэлцэн ирж буй хөлөг онгоцны нэр болон Далайн олон улсын байгууллагаас олгосон дугаар

Боомт

Ачаа тээврийн баримт бичгийг олгосон огноо

Далайгаар тос шатахууныг ханган нийлүүлэгчийн нэр, хаяг, утас

Бүтээгдэхүүний нэр /төрөл/

Тонн/Метрээр илэрхийлсэн тоо хэмжээ

15C дахь нягтрал, kg/m^3 - /мазутын тосыг ISO 3675-д нийцүүлж туршина/

Хүхрийн агуулга (% m/m) - /мазутын тосыг ISO 8754-д нийцүүлж туршина/

Энэхүү хавсралтын 18(1) журам болон 14(1) буюу (4)(а) журмын заалтуудад нийцүүлэн тос шатахууныг ханган нийлүүлж буйгаа тос шатахуун ханган нийлүүлэгчийн төлөөлөгч баримтаар гэрчилж гарын үсэг зурна.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улсанбаатар-12
Төрийн ордон

☎ 265958
Индекс: 14003

☎ 329487

Хангалтын хуудас 4